

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН
ЧУЛУУТЫН АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ”
ТӨСЛИЙН

2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-016982/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РИГЕСТРИЙН ДУГААР 2577453/

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

Ц.ЖАРГАЛНЭМЭХ

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“ХОНГОРЫН ОРД” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.БОЛОР

“ХОНГОРЫН ОРД” ХХК-ИЙН МЕНЕЖЕР

Д.ЭНХМЭНД

2022 ОН

ГАРЧИГ

1.ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Ерөнхий мэдээлэл	4
1.2. Төслийн байршил.....	5
2.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	7
3.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	9
4.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	10
5.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15
6.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	16
7.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
8.ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	20
9.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	22
10.АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ	24
11.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	25
12.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	26
13.ДҮГНЭЛТ.....	27

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.Төслийн талбайн булангийн цэгүүд	5
Хүснэгт 2.Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	7
Хүснэгт 3.Нөхөн сэргээсэн талбайн булангийн цэгүүд	10
Хүснэгт 4.Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10
Хүснэгт 5.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	16
Хүснэгт 6.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	17
Хүснэгт 7.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	20
Хүснэгт 8.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт.....	22
Хүснэгт 9.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	25
Хүснэгт 10.Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	26

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.Төслийн талбайн байршлын зураг.....	5
Зураг 2.Төслийн талбайн районы агаар, сансрын зураг.....	6
Зураг 3.Кемп болон тэр орчим агаарын тоосжилт хэмжих ажлын явц	8
Зураг 4.Геофизикийн уст цэгийн хайгуулын ажил болон худаг өрөмдөж тоолууржуулсан байдал.....	8
Зураг 5. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт болон Амьтдад нэмэгдэл тэжээл тавьж өгч байгаа байдал	8
Зураг 6.Нөхөн сэргээгдээгүй байдал	11
Зураг 7.Нөхөн сэргээгдээгүй байдал	12
Зураг 8.Дүйцүүлэх нөхөн сэргээлтийн ажил хийгдсэний дараа	13
Зураг 9.Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд.....	14
Зураг 10.Аюулгүй ажиллагааны зааварчилгаа болон ажлын хувцсаар бүрэн хангасан байдал	18
Зураг 11.Анхан шатны тусламжын хайрцаг бусдын нүдэнд ил харагдахуйц байршуулсан байдал	19
Зураг 12.Галын сургалт, осол гарцын схем зураг, цуглах цэг, аянга зайлуулагч зэргийн зураг	19
Зураг 13.Хогын ангилал сав болон хогын нэгдсэн цэг байгуулсан байдал	21
Зураг 14.Орчны хяналт шинжилгээ хийж байгаа байдал	23
Зураг 15.Орчны хяналт шинжилгээ хийж байгаа байдал	26

1. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Хонгорын орд” ХХК-ийн Цагаан чулуут алны үндсэн ордын талбайд 2022 онд хүдэр боловсруулах бага оврын баяжуулах үйлдвэр барьж 2020 онд үүсгэсэн 4мян.тн хүдэр боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

1.1.Ерөнхий мэдээлэл

Төслийн нэр

- “Цагаан чулуутын алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах” төсөл

Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

- “Хонгорын орд” ХХК
 - Улсын бүртгэлийн дугаар: 9011107085
 - Регистрийн дугаар: 2577453

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

- УБ хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 2-р давхар
Утас: +976 – 99106629, 99154223

Төслийн ангилал

- Байгаль орчинд нөлөөлөл байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралтын дагуу Уул уурхайн төсөл ангилалд хамаарна

Төслийн зорилго, үйл ажиллагаа:

- Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших Цагаан чулуутын MV-016982 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах бодитой болон боломжтой нөөцөд тулгуурлан уг ордыг ашиглах төсөл боловсруулан ордыг аж ахуйн эргэлтэд оруулж улс орны төсөвт өөрийн хувь нэмрээ оруулах, шинээр ажлын байр бий болгох, уул уурхайн салбарыг хөгжүүлэх зэрэгт оршино.

Төслийн үргэлжлэх хугацаа:


- 4 жил

1.2. Төслийн байршил

Цагаан чулуут алтны үндсэн ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хотоос баруун хойш 220 км, Баруунхараа буюу Баянгол сумаас хойш 60 км, Шарынгол сумаас чанх урагшаа 20 км зайд тус тус байршина. Засаг захиргааны хувьд Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутаг дэвсгэрт харьяалагдана.

Талбайн хэмжээ: 84.49 га


Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: М-48-105



Зураг 1. Төслийн талбайн байршилын зураг

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгүүд

№	Уртраг			Өргөрөг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	106	25	46.2	49	8	41.91
2	106	25	1.19	49	8	41.91
3	106	25	1.19	49	9	11.92
4	106	25	46.2	49	9	11.92



Зураг 2.Төслийн талбайн районы агаар, сансрын зураг

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Хүснэгт 2.Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2022 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2022онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
0	1	2	3	4	5
1	Агаарын чанар	Машин техникийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх	Уулын ажил хийгдээгүй бөгөөд түлшний машин, суудлын машинд тухай бүрт үзлэг хийж байсан	Дотоод зардал	
		Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	Үйлдвэрийн салхин дээр болон доор орчимд тоосны хэмжилт хийсэн	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт зардал тусгагдсан	
		Хүчтэй салхитай, тоосжилт ихтэй өдрүүдэд ажилчдад амны хаалт зүүлгэх	Уул нэвтрэлтийн ажил хийгдээгүй ч шаардлагатай үед амны хаалт хэрэглэж байсан	Дотоод зардал	
2	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Унд, ахуйн хэрэглээний уснаас сорьц Газарзүй-Геозкологийн хүрээлэн Усны шинжилгээний лабораторид шинжлүүлсэн. /Шинжилгээний хариуг хавсралтаас харна уу/	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт зардал тусгагдсан	
		Усны хайгуул, худаг гаргах, тоолууржуулах	Геофизикийн хайгуулаар уст цэг тогтоож худаг гаргаж тоолууржуулсан.	Дотоод зардал	
3	Хөрсөн бүрхэвч	Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх	Ямар нэг эвдрэлтэй машин тоног төхөөрөмж талбайд гараагүй бөгөөд хөрс хамгаалсан цемент шалтай газар зогсоож байсан болно	Дотоод зардал	
4	Ургамлан нөмрөг	Үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй газруудад зөвшөөрөлгүй автомашин, машин механизмуудын хөдөлгөөнийг хориглох	Үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй газруудад зөвшөөрөлгүй автомашин, машин механизм зөрчүүлэхгүй, зам гаргахгүй байхад анхаарч ажилсан.	Дотоод зардал	
		БО, Ой хээрийн түймрээс урьдчилсан сэргийлэх сургалтыг тогтмол явуулах татах	"Гал импекс" ХХК -аас өмнө жил авч байсан сургалтыг энэ жил ажилчдад тогтмол сургалт тавьж, галын булан шинээр хийж тэдгээрийг ашиглах зааварчилгаа өгч, галын хор ашиглах зааварчилгаа мөн өгч байсан	Осол, эрслийн хэсэгт зардал тусгагдсан	
5	Амьтны аймаг	Амьтдад нэмэгдэл тэжээл тавьж өгөх	Сэлэнгэ аймгийн Бугант тосгонд 500кг хэвэг, 100кг хучир тарааж тавьсан	-	200,000
Нийт дүн					200,000.00


Сөрөг нөлөө бууруулахад зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс



Зураг 3.Кемп болон тэр орчим агаарын тоосжилт хэмжих ажлын явц



Зураг 4.Геофизикийн уст цэгийн хайгуулын ажил болон худаг өрөмдөж тоолууржуулсан байдал



Зураг 5. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт болон Амьтдад нэмэгдэл тэжээл тавьж өгч байгаа байдал

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 онд уурхайн олборлолтын ажил хийгдээгүй, уурхайн бэлтгэл ажил болон 2020 онд бэлтгэсэн 4000 гариу тн хүдрийг боловсруулах ажил хийгдсэн тул техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх боломжгүй юм.

4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Хонгорын орд” ХХК нь Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар хэсгийн 5.1.8 дахь заалт “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээх” зорилгын дагуу Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас өгсөн дараах солбицлын хүрээнд нийт 5.0 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Мөн Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ойг нөхөн сэргээх, ойжуулах ажлын хүрээнд Баянгол сумын удирдлага, байгаль орчны газартай зөвшилцсөний үр дүнд 50ш нарс, 51ш улиас модыг төв зам тариалсан болно.

Хүснэгт 3.Нөхөн сэргээсэн талбайн булангийн цэгүүд

№	Уртгаг			Өргөрөг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	107	23	20.77	49	24	18.17
2	107	23	12.30	49	24	15.07
3	107	23	6.41	49	24	23.53
4	107	23	12.81	49	24	26.38

Хүснэгт 4.Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	2022 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх дүйцүүлхээр төлөвлөсөн ажил	2022 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын биелэлт	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
0	1	2	3	4	5
1	Сэлэнгэ аймгийн Баянгол сумын БО-ны газартай хамтран 100ш мод тарих	2022.10.06-10.07-ны хооронд 50ш нарс, 51ш улиас Баянгол сумын төвд тарьсан	101	47,363.64	5,210,000
2	Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт олон жил эвдэрч орхигдсон 46 24 18.17 107 23 20.77, 46 24 15.07 107 23 12.30, 49 24 23.53 107 23 6.41, 49 24 26.38 107 23 12.81 солбицол бүхий 5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэх	Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт олон жил эвдэрч орхигдсон 46 24 18.17 107 23 20.77, 46 24 15.07 107 23 12.30, 49 24 23.53 107 23 6.41, 49 24 26.38 107 23 12.81 солбицол бүхий 5 га талбайд	5.0 га	20,000,000	100,000,000
Нийт зардал мян. төг				105,210,000	

Техникийн нөхөн сэргээлт хийхийн өмнөх болон дараах үеийн зургууд



Зураг 6. Нөхөн сэргээгдээгүй байдал



Зураг 7.Нөхөн сэргээгдээгүй байдал





Зураг 8. Дүйцүүлэх нөхөн сэргээлтийн ажил хийгдсэний дараа

“ТЭРБУЛ МОД ТӨСӨЛ”-ИЙН ХҮРЭЭНД МОД ТАРЬЖ БАЙГАА БАЙДАЛ



Зураг 9.Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд

5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн олборлолтоос үүдэн нүүлгэн шилжүүлэлт болон нөхөн олговор олгох үйл ажиллагаа байхгүй. Тус ордын нөлөөллийн бүсэд айл өрхийн өвөлжөө, зуслан, гар худаг байхгүй болно.

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	2022 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нийт зардал
0	1	2	3	4
1	Археологийн болон Палеонтологийн дурсгал	Хэрэв уурхайн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирвэл төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.	MV-016982 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд соёлын биет өв илрээгүй болно.	-
Нийт дүн				-

7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус компани 2022 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төлөвлөсөн ажлуудыг дараах байдлаар хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 6.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	2022 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний осол эрсдэлийн менежментийн хүрээнд төлөвлөсөн ажил	2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
0	1	2	3	4	5
1	ХХАА-ы дугуу авах арга хэмжээ	Ажилтан бүрийг хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах	Ажилчдыг аюулгүй ажиллагааг хангах зорилгоор ажлыг хувцаар бүрэн хагасан бөгөөд аюулгүй ажиллагааны зааварчилгааг тухай бүрт өгч журнал үйлдэж байсан	36,496,872	
		Техник тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих, шаардлагатай үед засвар үйлчилгээг нарийн хяналт дор хийх	Техник тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж, шаардлагатай үед засвар үйлчилгээг цаг алдалгүй хийж журнал үйлдэж байсан	Дотоод зардал	
		Ажилчдад анхан шатны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх, анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг хяналтын өрөө эсвэл ажлын байранд ил харагдахаар газарт байрлуулах	Аюулгүй ажиллагааны үүднээс анх ажилд орсон өдрөөс ХАБЭА-ы зааварчилгааг өгдөг бөгөөд суурин кемпэд анхан шатны тусламжийн хайрцгийг бусдын нүдэнд ил харагдахаар байршуулж, сургалт тавьж байсан	Дотоод зардал	
2	Галын аюул гарах	Болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай галын хор, багаж хэрэгслүүдийг бүх объектуудад байрлуулах, галын аюулын үед ашиглах ослын гарцын зураглал хийж байршуулах	Болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай галын хор, багаж хэрэгслүүдийг бүх объектуудад байрлуулсан, галын аюулын үед ашиглах ослын гарцын зураглал хийж байршуулсан/Гал тогоо, амрах өрөө, үйлдвэр, Оффис/	Дотоод зардал	
		Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах	Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг сургалт, арга хэмжээ зохион байгуулсан	Дотоод зардал	

3	Байгалийн аюул гамшиг	Аянга цахилгааны аюулаас урьдчилан сэргийлэх, аянга зайлуулагч хийх	Кемп дээр 20-25м өндөртэй аяга зайлуулагч байршуулсан	250,000
Нийт дүн				36,746,872



Зураг 10. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа болон ажлын хувцсаар бүрэн хангасан байдал



Зураг 11. Анхан шатны тусламжын хайрцаг бусдын нүдэнд ил харагдахуйц байршуулсан байдал



Зураг 12. Галын сургалт, осол гарцын схем зураг, цуглах цэг, аянга зайлуулагч зэргийн зураг

8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 7.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	2022 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд төлөвлөсөн ажил	2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
0	1	2	3	4	5
1	Ахуйн	Ажилчдын хэрэглээнээс гарах хог хаягдлын нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэн Баянгол сумын нэгдсэн хогийн цэгт зөөвөрлөн хаях	Сэлэнгэ аймгийн Баянгол сумтай гэрээлэн ажилласан	100,000	1,200,000
		Ангилан ялгах хогийн савыг байршуулах	Шил лааз, хуванцар гялгар уут, бусад хог зэрэгт хогийн савыг ангилан байршуулсан		240,000
2	Үйлдвэрийн	Хог хаягдлыг цэг байгуулах	Кемпийн салхин доод хэсэгт нэгдсэн хогийн цаг байгуулсан	-	
3	Аюултай	Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын саванд савлаж хадгална. Аюултай хог хаягдал савлах хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна.	Тус талбайд аюултай хог хаягдал гарахгүй бөгөөд хогийн савыг хаягжуулсан /тайлбарыг зураг дээрээс харна уу/	-	
		Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах байх	Одоогийн байдлаар үйл ажиллагаанаас хамаараад ангилан ялгах 3 сав байршуулсан	-	
		Хуванцар сав, шил, лааз, дугуй, модны хаягдал, автомашины сэлбэг, төмрийн хаягдал, цаасны хаягдал гэх мэт дахин ашиглах, дахин боловсруулах боломжтой хаягдлуудыг нэг дор цуглуулж хуримтлуулах, боломжтой бол хоёрдогч түүхийг эд авах цэгт тушаах	Хуванцар сав, шил, лааз зэргийг ангилан ялгаад хоёрдогч түүхийг эд авах цэгт тушаасан	-	
Нийт дүн				1,440,000.0	

9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

2022 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн хүрээнд өмнөх жилийн судалгаатай харьцуулсан мониторингийн цэгүүд дээр хэмжилт зэргийг хийж мэдээллийн сан үүсгэн хийж гүйцэтгэлээ. Тус талбайд агаарын чанар, хөрсөн бүрхэвч, гадаргын болон газрын доорх усны чиглэлээр мониторингийн хэмжилт судалгааг хийж, хяналтын цэгийг тогтоосон болно (шинжилгээний үр дүн болон тайланг хавсралтаар хавсаргав).

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

№	2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөсөн ажил	2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
0	1	2	3	4
Агаарын чанар				
1	Тоос-Төслийн талбайд орчим-1 цэг, Дуу шуугиан хэмжээ-Төслийн талбай орчимд-1 цэг	Агаарын чанар болон дуу шуугианы хэмжилтийг 2 цэгээс сорьц авч Цаг уур, орчны шинжилгээний газар Байгаль орчны хэмжилзүйн төв лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав).	-	192,000
Хөрсөн бүрхэвч				
2	Хөрсний агрохимийн үзүүлэлт - Шимт хөрсний овоолго -1цэг, Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо - Шатах тослох материалын агуулах орчим -1, Хөрсний хүнд металлууд (Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr гэх мэт) -Эвдрэлд өртсөн талбай хөрснөөс 1	Төслийн талбайгаас нийт 4 цэгээс дээж авч “Нарт шуун консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Нийт хөрсний агрохимийн 4 дээж, хөрсний бохирдол тодорхойлох зорилгоор хөрсний хүнд металлын 2 дээж, хөрсний эрүүл ахуйн 1 дээжийг тус бүр авсан (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав).	-	700,000
Усны чанар				
3	Физик шинж чанар Химийн найрлага - Гүний худаг ус-2 цэг, Хаягдал умнаас-1 цэг	Газрын доорх болон хаягдал усны чанарыг тодорхойлох зорилгоор нийт 3 цэгээс усны сорьц авсан. Үүнд: Гүний худгаас нэг усны сорьц, Хаягдлын сангаас буюу саарал уснаас 2 дээж авч 1-ийг Итгэмжлэгдсэн лаборатори болох Алс болон Сэлэнгэ аймгийн Цэнгэг ус итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав).	-	398,330
Нийт дүн				1,290,330



Зураг 14. Орчны хяналт шинжилгээ хийж байгаа байдал

**10. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР
БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ**

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас зааж өгсөн 5.0 га талбайд тенхикийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн.

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх
удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	2022 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөсөн ажил	2022 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
0	1	2	3	4
1	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Сумын засаг захиргааны байгууллага болон орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг харгалзан үзэж хамтран ажиллаж байгаа /Нийгмийн хариуцлагын гэрээ, Тэр бум мод төсөл, шинээр худаг гаргах гэх зэрэг/	Гэрээний дүнгээр	
2	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Аваар ослын үед яаралтай арга хэмжээ авах бие бүрэлдэхүүн томилж, дотоод журмандаа тусгаж өгсөн	Дотоод зардал	
3	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ –нд хүргэж өгөх.	2022 оны биелэлтийн тайланг БОАЖЯ-нд хүргүүлсэн	Дотоод зардал	

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнах төлөвлөгөө	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийг бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт
0	1	2
1	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон үйл ажиллагааны тайлант уулзалтыг нөлөөллийн бүсийн оршин суугч нарт 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдөр уурхай дээр уулзалт зохион байгуулан тайлагнасан.
2	Сэлэнгэ аймгийн БОАЖГ-т тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлэх	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэвлэмэл хэлбэрээр 2022 оны 11-р сарын 01-ны өдөр хүргүүлсэн.
Нийт дүн		Дотоод зардал



Зураг 15. Орчны хяналт шинжилгээ хийж байгаа байдал

13. ДҮГНЭЛТ

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт байршин MV-016982 тоот “Цагаан Чулуут” алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах төслийн 2022 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн үр дүнд бид дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- 2022 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 – ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 1 дүгээр хавсралтад заасан аргачлалын дагуу боловсруулав;
- Тус компани нь 2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд нийт 144,887,202 төгрөг зарцуулсан байна.

Тус компани нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу Сэлэнгэ аймгийн байгаль орчин, Аялал жуулчлалын газар болон Сэлэнгэ аймгийн Баянгол сумын удирдлага Газрын албатай уялдаа холбоотой хамтран ажилласан. Хаягдал усыг Сэлэнгэ аймгийн “Сэлэнгэ цэнгэг ус” “Алс” зэрэг итгэмжлэгдсэн лабораторид, Орчны хяналт шинжилгээг “Нарт шүүн консалтинг” ХХК, Цаг уур Орчны шинжилгээний газар Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторид хийлгэж, Сэлэнгэ аймгийн нутагт эвдэрч олон жил орхигдсон 5.0 га талбайг нөхөн сэргээх буюу дүйцүүлэн хамгаалах ажлыг Сэлэнгэ аймгийн Ерөө сумын иргэн Бямбасүрэн овогтой Орхонтой гэрээлж, мод тарих болон бусад ажлыг өөрсдийн хүн хүчийг ашиглан хийж гүйцэтгэсэн.

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000144115

2007.06.18

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011107085

/ Хувийн хэргийн дугаар /

2577453

/ Регистрийн дугаар /

Хонгорын орд

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

01

/ дугаар /

1999.05.31

/ он, сар, өдөр /

0729

/ код /

Ашигт малтмалын ашиглалт

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

4610

4610

4721

Гадаад худалдаа

Худалдааны зуучлал

Хүнсний дэлгүүр

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1

/ гишүүдийн тоо /

10,000.0

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, 2-р давхар, Утас1: 99093846, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Оюуны өмч, улсын бүртгэлийн
ерөнхий газар Хуулийн этгээдийн
бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2017 он 6 сар 2 өдөр

456159924.

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Жадамбаа овогтой Ганболд-г Захирал-р томилсныг бүртгэв.	2016.09.02	С.Мөнхсанчир
2	Дахин гэрчилгээ олгов.	2017.06.02	Ж.Нямдорж
1	Ганболд овогтой Санчир -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2017.06.30	Э.Эрдэнэбилэг
2	Zeelie овогтой Andre Hubert Hendrik -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2019.03.13	Ж.Оюумаа
3	Улаанбаатар, Баянгол, 7-р хороо, 3 хороолол /16092/, 15, 12 тоот Утас1: 99093846, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв.	2021.11.23	Б.Батзориг
4	Эцсийн өмчлөгч бүртгэв.	2021.11.23	Б.Батзориг
5	4610 Гадаад худалдаа үйл ажиллагааг хассаныг бүртгэв. 46100 Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2021.11.23	Б.Батзориг
6	Сайнбаяр овогтой Болор-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2022.07.04	Э.Мөнхзаяа

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцаага хүтээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



* 0 0 0 1 4 4 1 1 5 *



АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛААЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар *MV-016982*

Ашигт малтмалын тухай Монгол улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэсдэн

Сэлэнгэ аймаг /хот/-ийн

Баянгол сум /дүүрэг/-ын

Цагаан чулуут нэртэй газарт орших

84.49 гектар талбай бүхий уурхайн талбайд

хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг

зөвшөөрч улсын бүртгэлийн 9011107085 тоот гэрчилгээтэй

"Хонгорын орд" ХХК -д

энэхүү тусгай зөвшөөрлийг 2032.09.02 дуустал

хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН КАДАСТРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БОЛОРМАА

2012 оны 1 сарын 6 өдөр

Улаанбаатар хот



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

MV-016982

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.








Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг		
				#	Уртраг	Өргөрөг
011-RI	<ul style="list-style-type: none">MR-004819 тоот тусгай зөвшөөрлийг нөхөн олгох Анх олгосон огноог 2002.09.02 тооцно	84.49 Га	0 Га	1	106° 25' 46.2" 49° 8' 41.91"	
				2	106° 25' 1.19" 49° 8' 41.91"	
				3	106° 25' 1.19" 49° 9' 11.92"	
				4	106° 25' 46.2" 49° 9' 11.92"	
				2011-1-6	ГЕОЛОГИ УУЛ УУРХАЙН КАДАСТРЫН ХЭЛТЭС УУ/0214 Э.Заяабат	



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-016982

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.






Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
011-RI	<ul style="list-style-type: none">Бүртгэв: MR-004819 тоот тусгай зөвшөөрлийг нөхөн олгох Анх олгосон огноог 2002.09.02 тооцноГУУКХ-ийн даргын 2012.01.06-ний 35 тоот шийдвэр	2012-1-6  <i>Handwritten signature</i>
012-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 11 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2012.09.02 – 2013.09.02 хүртэл	2012-08-20  <i>Handwritten signature</i>
013-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 12 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2013.09.02 – 2014.09.02 хүртэл	2013-08-27  <i>Handwritten signature</i>
014-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 13 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2014.09.02 – 2015.09.02 хүртэл	2014-08-22 
015-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 14 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2015.09.02 – 2016.09.02 хүртэл	2015-03-31 
016-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 15 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2016.09.02 – 2017.09.02 хүртэл	2016-09-01 
017-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 16 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2017.09.02 – 2018.09.02 хүртэл	2017-08-31 



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-016982

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
018-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 17 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2018.09.02 – 2019.09.02 хүртэл	2018-08-28 
019-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 18 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2019.09.02 – 2020.09.02 хүртэл	2019-08-21 
020-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 19 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2020.09.02 – 2021.09.02 хүртэл	 2020.08.27
021-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 20 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2021.09.02 – 2022.09.02 хүртэл	 2021.09.06
022-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 21 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2022.09.02 – 2023.09.02 хүртэл	 2022.09.02



АНХИГТ МАЛТМА БИЛЭГ
ҮЭРЭГ ЭРХЛЭХ ТАСРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2004 07 02

Дугаар 85

Улаанбаатар хот

*Цагаан Чулуут, Саарал хөтөлийн
алтны үндсэн ордын алтны нөөцийг
хүлээн авч, бүртгэх тухай*

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутаг дахь Цагаан Чулуут, Саарал хөтөлийн алтны үндсэн ордод 2003 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан дахь алтны нөөцийн тооцоо, түүнд хийсэн шинжээчийн дүгнэлтийг Эрдэс баялгийн зөвлөлийн 2004 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан тэмдэглэл дэх дүгнэлт, саналыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Сэлэнгэ аймгийн Баян гол сумын нутаг дахь Цагаан Чулуут, Сааралын хөтөлийн хайгуулын талбайд 2003 онд явуулсан эрэл-хайгуулын ажлын тайлан” дахь Цагаан Чулуут алтны үндсэн ордын бодитой (В) нөөцийг 54.81 кг, боломжтой (С) нөөцийг 239.27 кг, Саарал хөтөлийн алтны үндсэн ордын боломжтой (С) нөөцийг 338.84 кг-аар хүлээн авсугай.

2. Хуралдааны энэхүү тэмдэглэлийн дагуу хүлээн авсан алтны нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Геологийн мэдээллийн төв (Х.Гантөмөрт)-д зөвшөөрсүгэй.

3. Цагаан Чулуутын алтны үндсэн ордод тогтоосон алтны бодитой ба боломжтой нөөцөд тулгуурлан, түүнийг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах боломжтой гэж үзсүгэй.

4. ЭБЗ-ийн 2004 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны 17-01 дүгээр тэмдэглэл дэх дүгнэж тэмдэглэсэн хэсэг болон тэмдэглэлийн 9-д лиценз эзэмшигчид анхааруулж заасан зүйлийг зөвшөөрсүгэй.

5. Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг, хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБЗ-ийн хуралдааны тэмдэглэл, түүний дагуу гаргасан АМХЭГ-ын даргын энэхүү тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Геологийн мэдээллийн төвд хүлээлгэн өгөхийг “МЛГео” ХХК (Ц.Ягаан)-д даалгасугай.

ДАРГА

 Д.ЖАРГАЛСАЙХАН

237

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ ЯАМ
АШИГТ МАЛТМАЛЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2004 оны 6 дугаар сарын
24 - ний өдөр

Дугаар 17-01

Улаанбаатар
хот

Цагаан Чулуут, Саарал хөтөлийн
алтны үндсэн ордын хайгуулын
ажлын үр дүнгийн тайланг хэлэлцсэн
тухай

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутаг дахь Цагаан Чулуут, Саарал хөтөлийн талбайд 2003 онд гүйцэтгэсэн алтны үндсэн ордын хайгуулын ажлын үр дүнгээр геологич Г.Мягмарын зохиосон тайлан дахь алтны нөөцийн тооцоо, түүнд геологич Б.Болд-Эрдэнийн хийсэн шинжээчийн дүгнэлтийг авч хэлэлцээд Эрдэс баялгийн зөвлөлөөс ТЭМДЭГЛЭХ нь:

1. Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Цагаан Чулуут”-ын 84 га талбайд ашигт малтмал ашиглах 4819А, “Саарал хөтөл”-ийн 85 га талбайд ашигт малтмал ашиглах 5017А дугаартай лицензийг АМХЭГ-ын ГУУКА-аас Улаанбаатар хотын “Хонгорын орд” ХХК-д 2002 оны 9 дүгээр сарын 02 ба 2002 оны 10 дугаар сарын 18-ны өдөр тус тус олгосон ба “МЛГео” ХХК уг ордыг түрээслэн авч, өөрийн хөрөнгөөр хоногт 100 т хүдэр баяжуулах бага оврын уулын баяжуулах үйлдвэр (БОУБУ)-ийг Цагаан чулуутын ордыг түшиглүүлэн байгуулж, уулын далд малталт нэвтэрч, хүдэр олборлон нөөцөлж буйн зэрэгцээ алтны үндсэн ордын эрэл, хайгуулын ажлыг 2003 онд гүйцэтгэж, Цагаан Чулуут ба Саарал хөтөлийн алтны үндсэн орд гэж нэрлэн, Цагаан чулуутын ордод алтны бодитой (В) ба боломжтой (С) нөөц, Саарал хөтөлийн ордод алтны боломжтой (С) нөөцийг тогтоож, эрэл, хайгуулын ажилд нийт 33.9 сая төгрөг зарцуулсан байна.

2. Хойт Хэнтийн металлогенийн бүсийн Мааньтийн талбайд Б.Пүрэвсүрэн, О.Наранцэцэг нар 1996-1998 онд 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийж, Цагаан чулуутын алтны илрэлийн кварцын бүлэг судал (2003 оны хайгуулаар 1, 1а, 1б, 1в, 2, 3, 4, 5 гэж дугаарласан)-д алтны үндсэн ордын алтны урьдчилан үнэлсэн баялаг (P₁)-ийг 4 251.0 кг-аар үнэлсэн байна.

3. Цагаан чулуутын талбайд тархсан алт агуулсан кварцын судлуудыг 1, 1а, 1б, 1в, 2, 3, 4, 5, Саарал хөтөлийн талбайд тархсаныг 6, 7 гэж тус тус нэрлэсэн ба судлын өргөн 0.5-1.0 м, ховроор 3.5 м, судлын урт 50.0-450.0 м-т хэлбэлзэнэ.

Цагаан чулуут, Саарал хөтөлийн алтны үндсэн орд нь хүчиллэг болон суурилаг гүний чулуулгийн дотор тархсан, хүдрийн формацын хувьд алт-кварцын төрөлд хамаарах жижиг хэмжээний судлын төрлийн ордууд юм.

Эдгээр ордын эрэл, хайгуулын ажлыг 50 т/км эрлийн маршрут, 10 га талбайд геофизикийн соронзон ба цахилгаан хайгуул хийж, суваг 152.0 м³ (Цагаан Чулуутад 31 сувгаар 93 м³, Саарал хөтөлд 15 сувгаар 59 м³), Цагаан Чулуутад уулын далд малталт (штольн) 20 т/м, баганат өрөмдлөг 46.2 м ба 54.3 м-ийн гүнтэй 2 кооногоор 100,5 т/м-ийг тус тус гүйцэтгэж, тэдгээрээс уулын малталтаас ховилон сорьц 10б, протоочек сорьц 120-ыг авч, химийн шинжилгээг Аналабс лабораторид, эрдсийн шинжилгээ, алтны үлээлэг, жинлэлтийг “Хан хас” ХХК-ийн лабораторид тодорхойлуулсан байна.

238

Геофизикийн судалгааны ажлыг “Гео-канон” ХХК-ний геофизикч Я.Уламсайн 10 га талбайд соронзон, цахилгаан хайгуулаар гүйцэтгэсэн байна.

Гидрогеологийн судалгааг “Церкон” ХХК-ийн гидрогеологич С.Нарантуяа нар гүйцэтгэсэн ба энэ ажлаар нийт 132.7 т/м гидрогеологийн цооног өрөмдөж 25 м-ийн гүнд усны ундаргыг 6-8 л/сек-ээр тодорхойлж, худаг өрөмдөж монтэжлан, Цагаан чулуутын ордод барьсан бага оворын уулын баяжуулах үйлдвэр (УБҮ) хүртэл 800 м зайд хоолой татах замаар усан хангамжийн асуудлыг шийдсэн байна.

Баганат өрөмдлөгийн ажлыг “Хос Хас” ХХК-ийн өөрөө явагч ЗИФ-65М төрлийн өрөмдлөгийн төхөөрөмжөөр 2003 оны 12 дугаар сард гүйцэтгэж, нийт 100.5 т/м өрөмдсөн байна.

Цагаан чулуутын бага оврын УБҮ-ийг түүнээс 1.4 км зайд орших Баян гол сумын Нарангийн бригадаас 6 квт-ын цахилгаан дамжуулах шугам татаж цахилгааны асуудлыг шийджээ.

4. Зохиогчид Цагаан чулуут, Саарал хөтөлийн алтны үндсэн ордын нөөцийн тооцоог доорхи аргачлалаар тооцжээ.

- Хүдэр дэх алтны захын агуулга + 1 г/т,
- Хүдэржилтийн итгэлцүүр Цагаан чулуутын ордод 0.78, Саарал хөтөлийн ордод 0.67,
- Хүдрийн эзэлхүүн жинг 2,73 т/м³-ээр авсан байна.

Алтны сорьцыг СЭЗЯ-ны Сорьцын улсын хяналтын албаны Үнэт металлын сорьц тогтоох лабораторид 858 хэмээн тодорхойлжээ.

5. Цагаан чулуутын ордын алт агуулсан кварцын 1, 1^a, 1^b, 1^c, 2, 3, 4, 5 дугаар судалд эрэл, хайгуулын ажил гүйцэтгэж, эдгээрээс 1^b, 2, 3, 4 судалд нөөцийн тооцоо хийсэн байна. Үүнд:

1^b судалд: 50 м хүртэл гүнд алтны бодитой (В) нөөцийг 54.81 кг, алтны жигнэсэн дундаж агуулга 8.44 г/т, жинхэнэ зузаан 0.61 м, урт 100.0 м, хүдэржилтийн итгэлцүүр 0.78, 50-75 м хүртэл гүнд боломжтой (С) нөөцийг сорьц тооцолгүйгээр 27.04 кг, химийн цэврээр 23.46 кг, алтны жигнэсэн дундаж агуулга 8.44 г/т, жинхэнэ зузаан 0.61 м, хүдэржилтийн итгэлцүүр 0.78,

2 судалд: 25 м хүртэл гүнд алтны боломжтой (С) нөөцийг 10.67 кг, алтны жигнэсэн дундаж агуулга 3.58 г/т, жинхэнэ зузаан 0.7 м, урт 80.0 м, хүдэржилтийн итгэлцүүр 0.78,

3 судалд: 50 м хүртэл гүнд алтны бодитой (В) нөөцийг 28.32 кг, алтны жигнэсэн дундаж агуулга 4.89 г/т, жинхэнэ зузаан 0.68 м, урт 80.0 м, хүдэржилтийн итгэлцүүр 0.78, 50-75 м хүртэл гүнд боломжтой (С) нөөцийг 14.16 кг, алтны жигнэсэн дундаж агуулга 4.89 г/т, жинхэнэ зузаан 0.68 м, урт 80.0 м, хүдэржилтийн итгэлцүүр 0.78,

4 судалд: 50 м хүртэл гүнд алтны бодитой (В) нөөцийг 105.8 кг, алтны жигнэсэн дундаж агуулга 12.68 г/т, жинхэнэ зузаан 0.98 м, урт 80.0 м, хүдэржилтийн итгэлцүүр 0.78, 50-75 м хүртэл гүнд боломжтой (С) нөөцийг 52.92 кг, алтны жигнэсэн дундаж агуулга 12.68 г/т, жинхэнэ зузаан 0.98 м, урт 80.0 м, хүдэржилтийн итгэлцүүр 0.78.

Цагаан чулуутын ордын алтны нийт В ба С нөөцийг 294.06 кг - аар тооцоолжээ.

Саарал хөтөлийн ордын алт агуулсан кварцын 6, 7 дугаар судалд эрэл, хайгуулын ажил гүйцэтгэж, боломжтой (С) нөөц бодсон байна. Үүнд:

6 судалд: 25 м хүртэл гүнд алтны боломжтой (С) нөөцийг 2 блокийн хэмжээнд 31.5 кг, алтны жигнэсэн дундаж агуулга 3.23 г/т, жинхэнэ зузаан 0.93 м, урт 230.0 м, хүдэржилтийн итгэлцүүр 0.67,

7 судалд: 25 м хүртэл гүнд алтны боломжтой (С) нөөцийг 7.34 кг, алтны жигнэсэн дундаж агуулга 3.86 г/т, жинхэнэ зузаан 0.53 м, урт 80.0 м, хүдэржилтийн итгэлцүүр 0.67.

Сааралын хөтөлийн ордын алтны нийт С нөөцийг сорьц тооцолгүйгээр 38.84 кг-аар тооцоолсон байна.

Шинжээч Б.Болд-Эрдэнэ дээрхи нөөцийн тооцоонд оролцож, мөн хяналтын хэмжилт, тооцоо хийснээр нөөцийг зохиогчийн тооцсон хувилбараар хүлээж авахыг санал болгосон ба ЭБЗ-ийн хуралдааны үед гишүүдийн олонхийн саналаар алтны агуулга тодорхойлсон химийн шинжилгээг Аналабс лабораторид ААС-аар хийснийг харгалзан, нөөцийг зохиогчийн тооцсон хувилбараар хүлээн авах, харин Цагаан Чулуутын ордод алтны бодитой (В) нөөцийг зөвхөн штольн нэвтэрсэн хэсэгт 54.81 кг, үлдсэн хэсэгт боломжтой (С) нөөцийг 239.27 кг-аар, Саарал хөтөлийн ордлын алтны боломжтой нөөц (С)-ийг 38.84 кг-аар хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх, энэхүү бүртгэлд авсан геологийн нөөц орд газрыг ашиглах явцад батлагдаагүйтэй холбогдож гарсан аливаа асуудлаар ЭБЗ хариуцлага хүлээхгүй ба орд, түүний аль нэг блокийн нөөцийг ашиглахаар уулын ажлын төлөвлөгөө хийхийн өмнө баттай (А), бодитой (В) нөөц тогтоосон бол ашиглалтын хайгуул, боломжтой (С) нөөц тогтоосон бол гүйцээх болон ашиглалтын хайгуул хийж, ашиглах нөөцөө баталгаажуулах ёстой болохыг лиценз эзэмшигчид анхааруулах нь зүйтэй гэж үзэв.

6. “МЛГео” ХХК алт агуулсан кварцын 16 судалд 2 x 1.5 м-ийн огтлолтой, 20 м урт штольн малтаж, мөн 3 дугаар судлаас жижиг карьераар нийт 291.1 т жинтэй хүдэр олборлон, өөрийн бага оврын уулын баяжуулах үйлдвэрт баяжуулах үйлдвэрлэл-туршилтын ажлыг хийж, 2.3 кг алт ялган авч, Улсын эрдэнэсийн санд тушаасан байна. ШУА-ийн Хими-Технологийн Хүрээлэн хүдэр, түүний буталж, нунтагласан дээж, флотацид орж буй пульпа, флотацийн ёроолд тунасан материал, флотобаяжмалд Au, Cu, As, S-ийн агуулгыг тодорхойлох болон хүдэр, нунтагласан дээж уусгах, тундасжуулах шинжилгээг хийж, үйлдвэрийн төслийн хүчин чадал 100 т/хоног, хоногт боловсруулах хүдрийн 10%-иас ихгүй нь флотобаяжмал хэлбэрээр цианжуулагдахаар технологийн горим, тоног төхөөрөмжөө сонгосон нь хортой цианидийн зарцуулалтыг бууруулж, байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах нөхцлийг бүрдүүлсэн, Цагаан Чулуутын ордын хүдэр сульфид бага (< 2%)-тай алт-кварцын хүдэр учир тоног төхөөрөмж болон технологийн горимыг оновчтой сонгосон гэсэн дүгнэлт өгсөн ба ГТЛ энэхүү үйлдвэрийн дамжлагуудаас авсан 126.065 кг жинтэй дээж (анхдагч хүдрээс 70.2 кг, сэгсрэх ширээг тэжээж буй хоолойноос 11.051 кг, сэгсрэх ширээний баяжмалаас 8.986 кг, сэгсрэх ширээний хаягдлаас 13.268 кг, хутгагч агитароос 9.677 кг, флотацийн баяжмалаас 5.861 кг, флотацийн хаягдлаас 7.022 кг)-нд технологийн туршилт хийж, үйлдвэрийн гравитац нь сэгсрэх ширээн дээр боломжийн түвшинд ажиллан, флотаци нь шаардлагын хэмжээнд 90.3%-ийн металл авалттай баяжмал гаргаж байна гэж дүгнээд цаашид флотацийн хаягдлыг СІР

240

технологоор боловсруулах боломжтой, сэгсрэх ширээг төвөөс зугатах хүчний концентратораар солих нь металл авалтыг нэмэгдүүлэхээс гадна гравитац-флотац, гравитац-уусган шингээх зохимжтой хослолыг хэрэглэх, гидроциклон ангилагчийг давхар хэрэглэн, үйлдвэрлэлийн дамжлагыг боловсронгуй болгох боломжтой гэжээ.

7. Цагаан Чулуутын орд нь хөрсний усны төвшингээс дээш орших ба гидрогеолгийн судалгаагаар уст цэг илрүүлэн, улмаар гүний насос бүхий худаг байгуулсан нь ордыг ашиглах үеийн ундааны болон техникийн усан хангамжийг бүрэн шийдсэн гэж үзжээ.

8. Цагаан Чулуут ордыг ашиглах ТЭЗ-ийн урдчилсан тооцоогоор Цагаан Чулуут ордын бага оврын уулын баяжуулах үйлдвэр ордын бодитой (В) ба боломжтой нөөцийг 1.6 жилд олборлон, хөрөнгө оруулалтаа нөхөх, нийт 33.5 мян.т хүдэр олборлож, хаягдал 3%, бохирдолыг 8%, технологийн хаягдлыг 5%-иар тооцсноор 30.9 мян.т хүдрийг боловсруулан, химийн цэврээр 155.71 кг алт олборлон борлуулснаар борлуулалтын нийт орлого 3 321.7 сая төг, ашиглалтын зардал 1 734.0 сая төг, цэвэр ашиг 1 068.3 сая төг, 1 г алтны өөрийн өртөг 7328.0 төг байхаар тооцсон байна.

9. “МЛГео” ХХК Цагаан Чулуут, Саарал хөтөлийн алтны үндсэн ордын хайгуулыг нөөц тооцоолсон судлуудын хэмжээндээ ч бүрэн хийгээгүй, хайгуулыг голлон сувгаар хийсэн атал тэдгээрийг оновчгүй байршуулсан, бичиглэлийг нь тайланд оруулаагүй, өрөмдлөгөөр авсан мэдээллийг нөөцийн тооцоонд хэрэглээгүй, штольныг зураг дээр буруу байршуулсан, геофизикийн судалгааны үр дүнг хэрхэн ашигласан нь тодорхойгүй, Аналабс болон “Хан хас” ХХК-ийн лабораторид хийлгэсэн шинжилгээнээс 47 сорьцийн үр дүнгийн харьцуулалтыг хийсэн боловч үнэлэлт, дүгнэлт өгөөгүй, тайланд ордын “Хүдрийн найрлага, технологийн шинж чанар” бүлгийг бичээгүй, ШУА-ийн Хими-технологийн хүрээлэн, ГТЛ-д хийлгэсэн технологийн туршилтын үр дүн БОУБҮ-ийн урьдчилж сонгосон технологоор хүдрийг баяжуулах боломжтойг харуулсан хэдий ч ордод тохирсон хүдэр боловсруулах технологийн схемийг үнэмшилтэй хийж харуулаагүй, ТЭЗ-ийн урьдчилсан тооцоог шаардлагын хэмжээнд хийгээгүй, бүтээгдэхүүний өөрийн өртгийг буруу тооцсон, энэхүү тооцоонд хүдрийг далд аргаар олборлох, флотбаяжмалаа өөр газар боловсруулах, цианаар уусгах, хоргүйжүүлэх зэрэг зардал ихтэй ажилбаруудыг тооцоогүй, ордын хайгуулыг бүрэн хийж, ашигт малтмалын нөөцийг зохих журмын дагуу бүртгүүлээгүй, хууль тогтоомж, геологи, уул уурхайн үйл ажиллагааны технологийн дарааллыг үл ойшоон, геологийн 1:50 000-ны масштабын зураглал, ашигт малтмалын ерөнхий эрлийн үед тухайн талбай дахь алт агуулсан кварцын судлуудад үнэлсэн алтны таамагласан баялагт үндэслэн БОУБҮ-ийг 800 гаруй сая төгрөгөөр байгуулсан зэргийг заан тэмдэглэж, цаашид ордын боломжтой (С) нөөц тооцоолсон хэсэгт гүйцээх хайгуулын ажил болон ордыг ашиглах ашиглалтын ТЭЗҮ-ийг мэргэжлийн хүнээр үндэслэлтэй хийлгэж, ЭБЗ-өөр хэлэлцүүлэх, БО-ны хяналтын олон шатны үнэлгээнүүдийг зохих дүрэм, журмын дагуу хийлгэх, Ашигт малтмалын тухай хуулийн дагуу хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг холбогдох газруудад хугацаанд нь өгч, мэргэжлийн байгууллагуудтай холбоотой ажиллах, уул уурхайн салбарт оруулсан хөрөнгөө үр ашигтай ашиглахын үүднээс уурхайн геологич, ашиглалтын болон баяжуулагчийн мэргэжлийн хүмүүсийг тогтмол ажиллуулах, олборлохоор бэлтгэсэн хэсэгт ашиглалтын хайгуулыг хийх замаар эрсдэлээ багасгаж ажиллахыг лиценз эзэмшигчид анхааруулахаар тогтов.

Нөөцийн тооцоонд хийсэн шинжээчийн дүгнэлт, Зөвлөлийн гишүүдийн саналыг, үндэслэн Эрдэс баялгийн зөвлөл дараахь заалт бүхий тушаал гаргахыг АМХЭГ-ын даргад уламжлахаар шийдвэрлэв:

2471

1. “Сэлэнгэ аймгийн Баян гол сумын нутаг дахь Цагаан Чулуут, Сааралын хөтөлийн хайгуулын талбайд 2003 онд явуулсан эрэл-хайгуулын ажлын тайлан” дахь Цагаан Чулуут алтны үндсэн ордын бодитой (В) нөөцийг 54.81 кг, боломжтой (С) нөөцийг 239.27 кг, Саарал хөтөлийн алтны үндсэн ордын боломжтой (С) нөөцийг 38.84 кг-аар хүлээн авах;

2. Хуралдааны энэхүү тэмдэглэлийн дагуу хүлээн авсан алтны нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Геологийн мэдээллийн төв (Х.Гантөмөрт)-д зөвшөөрөх;

3. Цагаан Чулуутын алтны үндсэн ордод тогтоосон алтны бодитой ба боломжтой нөөцөд тулгуурлан, түүнийг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах боломжтой гэж үзэх;

4. Энэхүү тэмдэглэлийн 9-д заасан зүйлийг цаашдын ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “МЛГео” ХХК (Ц.Ягаан)-д анхааруулах;

5. Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг, хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБЗ-ийн хуралдааны энэхүү тэмдэглэл, түүний дагуу гаргасан АМХЭГ-ын даргын тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Геологийн мэдээллийн төвд хүлээлгэн өгөхийг “МЛГео” ХХК (Ц.Ягаан)-д даалгах.

ЭРДЭС БАЯЛГИЙН ЗӨВЛӨЛИЙН
ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА




Д.ГАНБААТАР

Б.БЭГЗСҮРЭН

ЭБЗ-ийн 2004 оны 6 дугаар сарын 24
- ний өдрийн хуралдааны 18 - 01
дүгээр тэмдэглэлийн хавсралт

Цагаан Чулуут, Саарал хөтөлийн алтны үндсэн ордын
нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

Судлын дугаар	Нөөц, блокийн дугаар	Судлын жинхэнэ зузаан, м	Судлын урт, м	Нөөц тооцсон гүн, м	Хүдрийн эзэлхүүн, м ³	Хүдрийн нөөц, т	Алтны жигнэсэн дундаж агуулга, т/м ³	Алтны нөөц, кг
<i>Цагаан Чулуут</i>								
3	C-1	0.68	80	50	2720.0	7425.6	4.89	28.32
	C-2	0.68	80	25	1360.0	3712.0	4.89	14.16
4	C-1	0.98	80	50	3920.0	10701.6	12.68	105.8
	C-2	0.98	80	25	1960.0	5350.8	12.68	52.92
1 ^б	B	0.61	100	50	3050.0	8326.5	8.44	54.81
	C	0.61	100	25	1525.0	4163.2	8.44	27.40
2	C	0.7	80	25	1400.0	3822.0	3.58	10.67
Дүн:	B					8326.5	8.77	54.81
	C					35205.2	7.4	239.27
<i>Саарал хөтөл</i>								
6	C-1	0.93	150	25	3487.5	9520.8	3.23	20.6
	C-2	0.93	80	25	1860.0	5077.8	3.23	10.9
7	C	0.52	80	25	1040.0	2839.2	3.86	7.34
Дүн:	C					17437.8	3.54	38.84
<i>Цагаан Чулуут, Саарал хөтөл</i>								
Нийт дүн:	B					8326.5		54.81
	C					52643.0		278.11

Тайлбар:

- Хүдрийн эзэлхүүн жин: 2.73 т/м³,
- Цагаан Чулуутын ордын хүдэржилтийн итгэлцүүр: 0.78,
- Саарал хөтөлийн ордын хүдэржилтийн итгэлцүүр: 0.67

Цагаан Чулуут, Саарал хөтөлийн талбайд 2003 онд явуулсан
эрэл-хайгуулын
ажлын гүйцэтгэлийн биелэлт.

д/д	Ажлын төрөл	Хэмжих нэгж	Төлөвлөсөн ажил		Биелэлт	
			биетээр	Сая ₮	биетээр	Сая ₮
1.	Бэлтгэл ажлууд					
	Төсөл, төсөв зохиолт, суурин боловсруулалт	%		0.5		0.5
2.	Хээрийн ажлууд					
	Эрлийн маршрут	т/км	50	0.125	50	0.125
	Геофизикийн ажил	ф/цэг		3.4		4.0
	Баганат өрөмдлөгийн ажил					
	Гидрогеологийн ажил	т/м	200	18.0	100.5	9.09
	Уулын ажил	т/м	150	15.0	132.7	13.27
	Суваг малтах					0.58
	Сорьцлолтын ажил	м-3	400	1.01	230	0.81
	Ховилон	бр/ээлж	200	0.17	120	0.10
	Протолочек	бр/ээлж	150	0.18	125	0.15
3.	Хээрийн ажлын дүн					28.125
4.	Лабораторийн ажлууд					
5.	Хан хас ХХК лаборатори	шир	250	0.875	160	0.56
6.	Analabs Pty ltd	шир	150	2250	120	1.8
	Геологийн төв лаборатори					
	Технологийн туршилт	бр/ээлж				2.5
	Хими Технологийн Хүрээлэн					
		шир	4	0.3	4	0.3
7.	Лабораторийн ажлын дүн					5.16
8.	Тээвэр	км	2600	0.65	2600	0.65
9.	Нийт ГХА-ын дүн					33.935

Ажлын гүйцэтгэл хянасан МЛГео ХХКомпанийн захирал *Ц.Ягаан* /
Ажлын гүйцэтгэл гаргасан геологич *Г.Мягмар* /



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 781

Улаанбаатар хот

Техник-эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн т/19-07-01 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших MV-016982 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Хонгорын орд ХХК-ийн Цагаан чулуут нэртэй алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсанд тооцсугай.

2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, нөөцийн хөдөлгөөн хийхийг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т зөвшөөрсүгэй.

3. Техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу уулын ажил явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.

4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан үйлдвэрийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.

5. Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших MV-016982 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Цагаан чулуут нэртэй алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт энэхүү тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг Хонгорын орд ХХК-д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2019 оны 05 сарын 14 өдөр

Дугаар Т/19-07-01

Улаанбаатар хот

*Сэлэнгэ аймгийн Баянгол сумын
нутагт орших Цагаан чулуутын
алтны үндсэн ордыг далд уурхайн
аргаар ашиглах ТЭЗҮ-г хэлэлцсэн
тухай*

“Хонгорын орд” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Эрдэнэс инженеринг” ХХК боловсруулсан Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших Цагаан чулуутын алтны үндсэн ордыг далд уурхайн аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэлд МУ-ын зөвлөх инженер С.Дэлгэрдалай зөвлөж, МУ-н зөвлөх инженер Б. Магванжав шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Техник-эдийн засгийн үндэслэл нь Оршил, Геологийн хэсэг, уул-технологийн хэсэг, Баяжуулах хэсэг, Дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Уурхайн хаалтын төлөвлөлт байгал хамгаалах нөхөн сэргээх, Эдийн засгийн үр ашиг, дүгнэлт зэрэг 9 бүлэг, дүгнэлт, хавсралт материал, хавсралт тооцоо бүхий 134 хуудас тайлбар бичиг, 20 хавсралт зургуудаас бүрдэж байна.

2. Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших Цагаан чулуут нэртэй MV-016982 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2004 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн хуралаанаар гаргасан дүгнэлтийг үндэслэн АМГ-ын даргын 2004 оны 07 дугаар сарын 02-ний өдрийн н 85 дугаар тушаалаар алтны үндсэн ордын нөөцийг боломжтой (B+C) зэргээр 294,08 кг алтыг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

3. Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо далд уурхай хаягдал 0,8%, бохирдол 26,98% байхаар тооцсон ба ордыг 4 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд магадалсан B' үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн далд уурхайгаас/нийт/ 280,5 кг алт олборлохоор төлөвлөсөн байна. Жилийн хүчин чадал 70 кг алт байна.

4. Цагаан чулуутын алтны үндсэн ордыг ашиглахад эдийн засгийн үр ашигтай нөөцөд тулгуурлан жилд гаргах бүтээгдэхүүн нь 70 кг алт байх ба 105 мян.төг/кг-р борлуулах эдийн засгийн тооцоог хийж ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.

5. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ уул-геологи, уул-техник болон ордын шинж чанар тогтцод тулгуурлан тооцоо судалгаа хийсэний үндсэн дээр далд уурхайн аргаар ашиглалт явуулах нь оновчтой гэж үзжээ.

6. Тус уурхайд MPC5-4 маркийн бетонон бэхэлгээний машин 1ш, YT-28 маркийн гар өрмийн машин 4ш, ХК20D маркийн ачигч машин 1ш, shen wei фирмийн өөрөө буулгагч 1ш зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар ТЭЗҮ-д тусгажээ.

7. Олборлолтын явцад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг MNS5915:2008, MNS5916:2008, MNS5918:2008, MNS5850:2008 зэрэг Монгол улсын стандарт зааварчилгааны дагуу гүйцэтгэж, уулын ажлын үр дүнд үүссэн ухашийг нөхөн дүүргэж тэгшлэх, тухайн бүсийн уур амьсгалын нөхцөл байдалд тохирсон мод, бутлаг ургамлаар биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж гүйцэтгэхээр зардлыг төсөлд тусгасан байна.

8. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 514.34 сая төгрөг зарцуулахаар тооцсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 20 сая.төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 286,11 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 78.00 сая төгрөг, төслийн хаалтын зардалд 87.67 сая төгрөг болон бусад зардалд 48 сая төгрөг зарцуулахаар тусгажээ.

9. Уурхайн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 1747.86 сая.төгрөг ба химийн цэврээр 212,7 алтыг 1кг-ыг 105 сая.төг-өөр борлуулахаар тооцон төслийн нийт хугацаанд 22.33 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 18.57 тэрбум төгрөгийн зардал гарган, 4.2 тэрбум төгрөгийн цэвэр ашиг олж, хөрөнгө оруулалтаа ашиглалтын 2.0 жилийн хугацаанд нөхөхөөр тооцжээ.

10. Төслийн ашиглалтын жилийн хугацаанд нийт 3.28 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд 10%-ийн хорогдуулалтын норм тооцсон өнөөгийн цэвэр үнэ цэнэ 1901.8 сая төгрөг, өгөөжийн дотоод норм 52% гарсан нь төсөл эдийн засгийн хувьд үр ашигтайгаар хэрэгжих боломжтой гэж үзжээ.

11. Төсөл хэрэгжсэнээр улс, орон нутгийн төсөвт жилийн хугацаанд 4872.1 сая.төг-ийг татвар төлбөр хэлбэрээр төвлөрүүлэх ба 76 хүний ажлын байр шинээр бий болохоор төсөлд тусгажээ.

12. Техник, эдийн засгийн үндэслэл нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, уулын ажлын төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.

13. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэл нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн

үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

14. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан болон усан хангамж, дэд бүтэц, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн "Эрдэнэс инженеринг" ХХК хариуцах, түүний үнэн бодит байдал, чанарт гаргасан дүгнэлтийг шинжээч Монгол улсын зөвлөх инженер Б. Магванжав-д хариуцах.

15. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж, ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байх нь зүйтэй.

16. Захиалагч компани Техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах тухай Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын шийдвэр гарснаас хойш 5 хоногт багтаан Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын дарга гаргасан шийдвэрээ түдгэлзүүлэх, цуцлах эрхтэйг анхааруулах нь зүйтэй.

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмал, газрын тосны газрын даргад Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн "Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших Цагаан чулуутын алтны үндсэн ордыг далд уурхайн аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэл"-ийг хүлээн авах шийдвэр гаргахыг уламжлахаар шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.МОНХТӨР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.БОЛД-ЭРДЭНЭ

Шилжүүлгийн мэдээлэл

Журналын №: 60473467

Системийн огноо: 2022.05.12

Нэр: БЛУ ГОЛД ИНВЕСТМЕНТ ХХК

Илгээгч	Дансны дугаар: 410048901	Нэр БЛУ ГОЛД ИНВЕСТМЕНТ ХХК	Дүн 3,168,000.00 MNT	Ханш 1.00
/ гурван сая нэг зуун жаран найман мянган төгрөг /				
Хүлээн авагч	Банкны дугаар: 90	Банкны нэр Төрийн сан	3,168,000.00 MNT	1.00
	Дансны дугаар 100900013406	Нэр БО нөхөн сэргээх баталгаа		

Гүйлгээний утга:

EB -MV-016982 тоот лицензийн талбайн 2022 оны нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр

Танд баярлалаа

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан

Салбар, тооцооны төв:

Гарын үсэг:

Тамга:

Огноо: ____ Он __ Сар __ Өдөр



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,
Утас/Факс: (976)-7036-3653

2022.03.02 № 83

танай _____-ны № _____-т

**Эргэлтийн цэгийн координат
хүргүүлэх тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар хэсгийн 5.1.8-д “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8000 га талбайг нөхөн сэргээнэ” гэсэн зорилт тусгагдсан.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн зорилтыг үндэслэн Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын хамтарсан 2020 оны “Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” 167, А/698, А/336, А/242 тоот тушаалаар батлагдсан “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээ хэрэгжиж байна.

Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд БОАЖСайдаас ирүүлсэн албан бичигт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд тодорхой хэмжээ бүхий эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг хийлгүүлэх талаар тусган хэрэгжилтийг хангуулахаар заасан.

Дээрх зорилт, чиглэлийн хүрээнд Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт эвдэрч олон жил орхигдсон нөхөн сэргээлт хийгээгүй талбайгаас тодорхой хэмжээ бүхий талбайн нөхөн сэргээлтийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд төлөвлөн гүйцэтгүүлэхээр газарзүйн солбицлыг тодорхой зааж албажуулан ажиллаж байна.

Иймд танай компани

49 24 18.17 107 23 20.77


49 24 15.07 107 23 12.30

49 24 23.53 107 23 6.41

49 24 26.38 107 23 12.81

солбицол бүхий эвдрэлд орж эзэнгүй орхигдсон 5 га талбайд холбогдох журам, стандартын дагуу нөхөн сэргээлт хийж хамтран ажиллана уу.

ДАРГА



З.ТҮВШИНТӨГС



“БЛУ ГОЛД ИНВЕСТМЕНТ” ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

...../С.БОЛОР/

БАТЛАВ.

ИРГЭН.

СЭЛЭНГИЙН ЕРӨӨ СУМ 3-Р БАГ

...../Б.ОРХОН/

**ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН
АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2022 оны 08 сарын 23 өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү хайгуулын ажил гүйцэтгэх гэрээ /цаашид “гэрээг” гэх/-г: Нэг талаас Регистрын **6064116** дугаартай, Нийслэлийн Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьяангүний гудамж, 5/1 байр 302 тоот хаягт байрлах “**Блу голд инвестмент**” ХХК (цаашид “А тал” гэх),

Нөгөө талаас Сэлэнгэ аймгийн, Ерөө сумын 3 дугаар баг, 3-36 тоот хаягт оршин суугч **Бямбасүрэн овогтой Орхон** /РД:МТ72112410/ (цаашид “Б тал” гэх) нар нь (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээний зорилго нь Б тал нь А талд нөхөн сэргээлт хийхээр орон нутгийн захиргааны байгууллагаас хувиаралсан талбай болох Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Бугант 3 дугаар баг, Өлөнтийн голд байрших

49 24 18.17 107 23 20.77

49 24 15.07 107 23 12.30

49 24 23.53 107 23 06.41

49 24 26.38 107 23 12.81 булангийн цэг бүхий солбилцол, координатын талбайд энэ гэрээний 1 дүгээр зүйлийн 1.2-г заасан Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Хийгдэх ажил: Монгол Улс, Сэлэнгэ аймгийн Бугант 3 дугаар багын газарт орших 1.1-д заасан координат бүхий талбайд Техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэнэ. Б Талаас Техникийн нөхөн сэргээлтийн талбайг өөрийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түлш шатахуун, түүх эд материал, хүн хүч зэрэгийг ашиглан гүйцэтгэж,

комисст хүлээлгэж өгөх бүх ажлыг холбогдох хууль, дүрэм, журам, стандартанд нийцүүлэн чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- 1.2.1 Техникийн нөхөн сэргээлтийн ажил нь норм, стандартад нийцүүлэн өөрийн тоног төхөөрөмжөөр хийж гүйцэтгүүлнэ.
- 1.3 А тал нь гэрээний 1.2-т заасан ажлын хүрээнд хийгдэх ажилд гэрээнд заасан төлбөрийг заасан хугацаанд шилжүүлнэ.
- 1.4 Б тал нь Сэлэнгэ аймгийн “Байгаль орчин, Аялал жуулчлалын газар” 2022.03.02-ны өдрийн 83 тоот албан бичгийн дагуу тус гэрээний 1.1-т заасан булангийн цэг бүхий 5.0 га талбайг холбогдох дүрэм, журам зааварын дагуу техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Гэрээгээр ажил гүйцэтгэх хугацаа нь 2022 оны 08-р сарын 25-ний өдрөөс 2022 оны 09-р сарын 25-ны өдөр хүртэл хугацаатай хийж гүйцэтгэнэ.

Гурав. Гэрээний үнэ болон төлбөр төлөх аргачлал

- 3.1 Гэрээнд заасан төлбөр 100 000 000 ₮ /НӨАТ багтаагүй үнэ/ болно.
- 3.2 Энэ гэрээнийн 3.1-т заасан гэрээний төлбөрт гэрээнд заасан газарт нөхөн сэргээлт хийхэд шаардлагатай бүх зардал багтсан болно.
- 3.3 Төлбөр төлөх аргачлал:
 - 3.3.1 Гэрээний урьдчилгаа төлбөр 50% буюу 50 000 000₮ -г ажил эхлэхээс өмнө “Хаан банк”-ны 5677075414 тоот Б.Орхон болон 5045136193 тоот Т.Нарандулам зэрэг дансанд шилжүүлнэ.
 - 3.3.2 Нөхөн сэргээлтийн ажил 100% гүйцэтгэсний дараа буюу Аймгийн комисс хүлээн авсаны дараа 50%-г буюу 50 000 000₮-г дээрх дансанд төлнө.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг

4.1 А талын эрх, үүрэг

- 4.1.1 Энэхүү гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн бүхий л ажлын үр дүн, түүнтэй холбогдох баримт бичиг А талд шилжинэ.
- 4.1.2 Б тал дээрх координатын дагуу болон холбогдох дүрмийн дагуу нөхөн сэргээлийн ажлыг гүйцэтгээгүй бол А тал гэрээг дангаар цуцлалж энэ гэрээний дагуу Б талд төлсөн төлбөрөө буцаан шаардах эрхтэй. Үүнээс үүдэн гарсан бүх хохиролыг Б тал хариуцана.

- 4.1.3 Өөрийн ажилтныг томилон ямар ч үед Б талын нөхөн сэргээлтний ажлын явцад хяналт тавина.
- 4.1.4 Гэрээгээр тохиролцсон төлбөр төлөх аргачлалын дагуу цаг тухайд нь Б талд холбогдох төлбөрийг төлнө.

4.2 Б талын эрх, үүрэг

- 4.2.1 Гэрээгээр тохиролцсон төлбөр төлөх аргачлалын дагуу нөхөн сэргээлтний ажлын төлбөрийг А талаас хүлээн авна.
- 4.2.2 Нөхөн сэргээх талбайн булангийн цэгийг бүрэн тогтоосны үндсэн дээр нөхөн сэргээлтний ажлыг гүйцэтгэх ба Сэлэнгэ аймгийн “Байгаль орчин, Аялал жуулчлалын газар” 2022.03.02-ны өдрийн 83 тоот албан бичигт заасан талбайгаас өөр газарт нөхөн сэргээлт хийсэн тохиолдолд холбогдох зардлыг өөрөө хариуцаж, энэ гэрээнд заасан нөхөн сэргээлт хийх үүргээ бүрэн гүйцэтгэнэ.
- 4.2.3 А талын зөвшөөрөлгүйгээр бусад гуравдагч этгээдэд энэхүү гэрээтэй холбоотой нөхөн сэргээлтний талбайг ил болгох, нөхөн сэргээлтний талбайд олборлолт, хайгуул зэрэг нөхөн сэргээлтээс өөр үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 4.2.4 Гэрээгээр гүйцэтгэх ажлыг бүрэн өөрөө хариуцан гүйцэтгэх ба ажилчидтаагаа өөрийн нэрээр гэрээ байгуулж ажиллах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин зэрэг эрсдэлүүд, түүнээс гарах үр дагаварыг Б тал бүрэн хариуцна. /Үүнд А тал ямар хамааралгүй болно./
- 4.2.5 Б тал гэрээнд заасныг хатуу баримтлан ажил гүйцэтгэх ба тохиролцсон ажлын хүрээнд гаргахгүй, зөвхөн нөхөн сэргээлтний талбайд нөхөн сэргээлтийг хийнэ.
- 4.2.6 Б тал нь А талын шаардсан хугацаанд нөхөн сэргээлтний ажлыг эхлүүлж, үргэлжлүүлнэ.
- 4.2.7 Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон энэхүү гэрээний тохиролцоог хатуу баримтлан нөхөн сэргээлтний ажлыг явуулна. Хууль тогтоомж, дүрэм журмуудыг зөрчин ажил гүйцэтгэсний улмаас холбогдох эрх бүхий байгууллагаас А талд торгууль, алданги, суутгал, хураамж оногдуулсан бол Б тал А талын бүх хохиролыг хариуцан барагдуулна.

Тав. Хариуцлага

- 5.1 А тал гэрээний дагуу цаг тухайдаа төлбөрөө төлөөгүй бол төлөгдөөгүй үнийн дүнгийн 0.3 хувийн алдангийг Б талд төлнө.
- 5.2 Б тал гэрээгээр тохиролцсон техникийн нөхөн сэргээлтний ажлыг гүйцэтгээгүй бол гүйцэтгээгүй ажлын төлбөрийг А шаардсан хугацаан буцаан шилжүүлэх ба Б тал А талын

шаардсан хугацаанд төлбөрийг буцаан шилжүүлээгүй нөхцөлд А талын шаардсан хугацаанаас хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувийн алдангийг Б тал нь А талд төлөх хариуцлага хүлээнэ. Харин Б тал гэрээгээр тохиролцсон техникийн нөхөн сэргээлтийн ажлыг тохиролцсон хэмжээнд чанарын өндөр түвшинд гүйцэтгээгүй тохиолдолд А тал ажлыг өөр гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж, гуравдагч этгээдээр гүйцэтгүүлсэн ажлын хөлсийг Б тал төлнө.

5.3 Б тал гэрээгээр тохиролцсон хугацаанаас хэтрүүлсэн бол тухайн ажлыг гүйцэтгэх үнийн дүнг гүйцэтгэсэн ажлын хувиар төлбөрийг тооцон хоног тутамд 0.1 хувийн алданги төлнө.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйл

6.1 Давагдашгүй хүчин зүйл үүсэж гэрээ хэрэгжих боломжгүй үед, талууд хариуцлагаас чөлөөлөгдөх ба бодит хийгдсэн ажлын хэмжээгээр тооцоо нийлж төлбөрийг төлнө. Илүү төлсөн хэсгийг буцаан олгоно.

6.2 Давагдашгүй хүчин зүйл үүссэнээс Б талын техник хэрэгсэл тоног төхөөрөмж эсвэл ажилтан хохирсон бол А тал ямар нэгэн төлбөр төлөх хариуцлага үүрэхгүй.

6.3 Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнд орсон тал нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Долоо. Маргаан шийдвэрлэх

7.1 Энэхүү гэрээнээс үүссэн эсвэл энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд хэлэлцэж шийдвэрлэнэ. Хэлэлцээрт хүрэхгүй бол Монгол Улсын Шүүхээр шийдвэрлэнэ.

Найм. Гэрээ цуцлах, дуусгавар болох

8.1 Энэхүү гэрээний хугацаа нь дор дурдсан үндэслэлээр дуусгавар болно.

8.1.1 Гэрээний хугацаа дуусгавар болж талууд цаашид сунгахгүй болсон;

8.1.2 Талууд харилцан тохиролцож гэрээг цуцласан.

8.2 Гэрээг дараах үндэслэлээр цуцлана.

8.2.1 Талууд харилцан тохиролцож;

8.2.2 Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа /2 ба түүнээс дээш/ ноцтойгоор зөрчсөн.

8.3 Гэрээг талуудын аль нэг нь хугацаанаас нь өмнө цуцлах тохиолдолд энэ тухайгаа нөгөө талдаа 7 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

Ес. Бусад

9.1 Энэхүү гэрээний гүйцэтгэл болон гэрээнд дурдагдаагүй зүйлүүдийг талууд харилцан тохиролцож нэгдмэл санаанд хүрч нэмэлт гэрээг байгуулна. Нэмэлт гэрээ болон гэрээ нь хуулийн өмнө адил тэгш хүчин төгөлдөр.

9.2 Талууд төсөв, ажлын хэмжээ /тооцоо/-г хүлээн зөвшөөрсөн ба талуудын аж ахуй нэгжийн гэрчилгээний болон хууль ёсны паспортын хуулбар зэргийг гэрээнд хавсаргана.

9.3 Энэхүү гэрээ нь гарын үсэг зурж тамга дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Энэхүү гэрээг Монгол хэл дээр нэг хэлбэрээр 2-н хувь үйлдэв. Талууд тус бүр нэг хувийг хадгалах ба бүх хувь хуулийн адил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

А тал:

“Блү Голд Инвестмент” ХХК
Регистрын дугаар:6064116

Хаяг:СБД, 1-р хороо,
Жамьяангүний гудамж 5/1 байр 303

Утас:11-311109

Гүйцэтгэх захирал: Сайнбаяр овогтой Болор

Гарын үсэг _____



Б тал:

Регистрын дугаар: МТ72112410
Хаяг: Сэлэнгэ аймгийн Ерөө сум, 3 дугаар баг

3-36 тоот хаягт оршин суух

Утас: 99048553

Бямбасүрэн овогтой Орхон

Гарын үсэг _____

Гэрээ байгуулсан хугацаа: 2022 он 08 дугаар сарын 25-ний өдөр

Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авсан тухай акт

2022 оны 10-р сарын 13-ны өдөр

№5

Сүхбаатар сум

д/д	Асуулт	
1	Байршил Аймаг, нийслэл: сум, дүүрэг: баг, хороо: Газрын нэр:	Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутаг дэвсгэрт харьяалагдана.
2	Аж ахуйн нэгжийн нэр: Хаяг: Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: Регистр:	“Хонгорын орд” ХХК Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 2-р давхар Гэрчилгээний дугаар: 9011107085 Регистрын дугаар: 2577453
3	Тусгай зөвшөөрлийн дугаар: Ордын нэр: Талбай /га-аар/	MV-016982 Цагаан чулуут алтны үндсэн орд 84.49 га
4	“Хонгорын орд” ХХК-ийн нөхөн сэргээлт хүлээлгэн өгсөн албан тушаалтан: Овог нэр: Утас:	“Хонгорын орд” ХХК-ийн Менежер Д.Энхмэнд 86021757
5	Нөхөн сэргээлтийн ажлыг газар дээр нь хэмжиж зураглал үйлдсэн мэргэжлийн байгууллагын нэр: Хаяг:	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны газрын даамал хэмжилт хийж зураглал үйлдсэн.
6	Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, чанар, үр дүн	
	Нөхөн сэргээлтийн хэмжээ Нэг. Техникийн нөхөн сэргээлт Талбайн хэмжээ /Га-аар/ Хийсэн ажлын хэмжээ /мян.м ³ -ээр/ Зардал /төгрөгөөр/ Хоёр. Биологийн нөхөн сэргээлт Талбайн хэмжээ /Га-аар/ Тарьсан мод, ургамал /төрлөөр/ Зардал /төгрөгөөр/	2022 оны БОМТ-нд тусгагдсан дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Ерөө сумын 3-р багийн нутаг Их Өлөнтийн ам нэртэй газарт 5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 100,000,000.00 төгрөг зарцуулан гүйцэтгүүлсэн.
7	Дүйцүүлэн хамгаалах чиглэлээр гүйцэтгэсэн ажлын танилцуулга, үр дүн Ерөө сумын Их Өлөнтийн ам нэртэй газарт 5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг Б.Орхонтой гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлсэн.	
8	Нэмэлт мэдээлэл /1:2000 масштабтай зураглал, шинжилгээний дүн, фото зураг, хүлээлгэн өгсний дараа хийх хяналт мониторингийн зардалтай холбоотой баримт материалыг хавсаргаж болно/	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлт хийгдсэн талбайд цаашид Ерөө сумын Засаг дарга, Бугант тосгоны захирагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар хяналт тавьж хамгаалах

	нь зүйтэй. 1:10 000 масштабтай зураглал, фото зураг хавсаргав.
--	--

Нөхөн сэргээлт хийсэн тухай:

ДҮГНЭЛТ:

1. “Хонгорын орд” ХХК нь 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу Монгол Улсын MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага” стандартын 1-р хүснэгтийн холбогдох заалтууд болон 6.1, 6.2 заалт, MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт” зэрэг стандартуудыг мөрдлөг болгон техникийн нөхөн сэргээлтийн ажлыг нийт 5 га талбайд хийсэн байна.
2. Ерөө сумын Засаг дарга, Бугант тосгоны захирагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар 2022 онд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг уул уурхайн эвдрэлд оруулахгүй байхад онцгой анхаарч, бүрэн бүтэн байдлыг бүрэн хариуцна.
3. “Хонгорын орд” ХХК нь 2022 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд тусгагдсан нөхөн сэргээлтийн ажлыг 100 хувьтай хийж гүйцэтгэсэн гэж дүгнэлээ.
4. Техникийн нөхөн сэргээлтийн ажлын 1:10 000 масштабтай зураг, нөхөн сэргээлт хийхийн өмнөх болон дараах үеийн фото зургийг хавсаргав.

АКТ ГАРГАСАН:


Комиссын дарга:

Ерөө сумын Бугант тосгоны захирагч



/Д.Эрдэнэбулган/


Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга



/З.Түвшинтөгс/

Гишүүд:

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлий, уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн



/Б.Оюун-Эрдэнэ/

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
Усны асуудал хариуцсан мэргэжилтэн


/Г.Хонгор/

Ерөө сумын байгаль хамгаалагч

/Л.Гансүх/

Бугант тосгоны газрын даамал

/Х.Байгалмаа/

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

“Хонгорын орд” ХХК-ийн Захирал


/Ж.Ганболд/




ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙГ НЬ ГАЗАРТ БЭХЭЛСЭН НЭГЖ ТАЛБАРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар:

Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн овог нэр: Хонгорын орд ХХК

Регистрийн дугаар:

Хаяг: Сэлэнгэ аймгийн Ерөө сум Бугант тосгон Их Өлөнтийн ам /Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ/



Нэгж талбар:

№	X	Y	H	Цэг	Зай
1	5475385.416	673021.400	800.000	1-2	156.19
2	5475477.496	673147.567	800.000	2-3	300.35
3	5475229.085	673316.384	800.000	3-4	195.95
4	5475127.955	673148.546	800.000	4-1	287.15

Зургийн масштаб 1:10000 (1 сантиметр 100 метр багтана)

Эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэгжүүлж, солбилцолжуулсан үндэслэлийн цэг:

Цэгийн солбицол 1: X 5565993.103 Y 585243.148 H 594.247

Цэгийн солбицол 2: X Y H

Цэгийн солбицол 3: X Y H

Талбайн хэмжээ: 51478 квадрат метр

Хэмжилт үйлдсэн:

Огноо

2022.10.13

Газрын даамал: *Х. Байгалмаа*





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

УСНЫ ГАЗАР

Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn

2022.06.07 № 01/674

танай 2022.05.22-ны № 22/76 -Т

“ХОНГОРЫН ОРД” ХХК-Д

Танай байгууллагын 2022 оны 22/76 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Усны тухай хуулийн 28.4 дэх заалтыг үндэслэн, холбогдох бичиг баримтыг судалж үзээд ашигт малтмал ашиглалтын MV-016982 дугаартай тусгай зөвшөөрөлтэй Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт байрлах “Цагаан чулуутын алтны үндсэн орд”-ыг далд аргаар ашиглах төслийн ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг Хараа-Ерөө голын сав газрын захиргаанд.

Хавсралт 4 хуудастай.

ДАРГА  Ш.МЯГМАР



183221554

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2022 оны 06 дугаар
Сарын 07-ны өдөр

Дугаар-128

Улаанбаатар
хот

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

“Хонгорын орд” ХХК, захирал Ж.Ганболд, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Жаргалан хотхон 4-р байр, 9 тоот. утас: 99093846, 99154223. Улсын бүртгэлийн дугаар: 9011107085 регистрийн дугаар: 2577453.

2. Төслийн нэр, байршил

“Цагаан чулуутын алтны үндсэн орд”-ыг далд аргаар ашиглах төсөл нь Улаанбаатар хотоос баруун хойш 200км, Шарын голын нүүрсний уурхайгаас зүүн урагш 25км зайд байрлана. Хараа голын сав газарт хамаарагдана.

3. Төсөл хэрэгжүүлэгч

“Хонгорын орд” ХХК

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /X,Y/

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-016982 Талбайн хэмжээ: 84.49га

№	Солбилцол	
	Уртраг	Өргөрөг
1	106°25'46.2"	49°8'41.91"
2	106°25'1.19"	49°8'41.91"
3	106°25'1.19"	49°9'11.92"
4	106°25'46.2"	49°9'11.92"

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт

Алтны үндсэн ордыг далд аргаар олборлон, баяжуулах;

6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/

Уурхайн олборлолтод:

• Ново маркийн автосамосвал 1ш	• Sem655D маркийн утгуурт ачигч 1ш
--------------------------------	------------------------------------

Баяжуулалтад:

• GZT-0724 маркийн чадалтай чичиргээт шигшүүр 1ш	• PE250*400 маркийн хацарт бутлуур 1ш
• ШМ-1800 маркийн бөөрөнцөгт тээрэм 1ш	• STLB30 маркийн гравитацийн сепаратор 1ш
• B500 маркийн туузан конвейр 2ш	• ST-500 маркийн гравитацийн сэгсрэх ширээ 2ш
• TS65 маркийн динамик насос 5ш	

Технологи:

Гравитацийн аргаар баяжуулна.

Ажиллах горим:

71 хүн өдөрт 2 ээлжээр 9 цаг, нийт 207 хоног ажиллана.

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ

2022 онд 16090м³ элс олборлон 67.4кг алт авахаар төлөвлөсөн байна. “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ний хүрээнд 1000ш мод тарина.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/

Унд ахуйн хэрэгцээт усыг гүний худаас, технологи болон зам талбайн усалгаа, биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усыг шүүрлийн ус болон гүний худаас хангана. Хоногт унд ахуйн хэрэгцээнд 10.65м³ ус ашиглана.



9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/

Нийт 5.8л/сек ундаргатай 2ш гүний худагтай. Эргэлтийн усан сангийн эзлэхүүн 400м³, хаягдлын сангийн эзлэхүүн 2000м³ байна.

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур, /насосны хүчин чадал, марк/

№	Солбилцол	Тоолуурын марк	Насосын марк	Худгийн ундарга
1.	106°25'41.6" 49°08'71.6"	LXSG-25	FROG-5QJ	3.6л/сек
2.	106°25'57.20" 49°07'23.86"	LXSG-40	FROG-5QJ	2.2л/сек

11. Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт, диаметр/

Худгаас эргэлтийн усан санд ус дамжуулах 30м урт 30мм голчтой уян хоолойтой.

12. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин

Ахуйн бохир усыг хөрсөнд нэвчүүлэн зайлуулна.

13. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл

Цагаан чулуутын алтны үндсэн орд"-ыг далд аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2019 онд "Ашид Ананда" ХХК хийж гүйцэтгэсэн.

14. Онцгой нөхцөл

-Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор Усны газарт ирүүлэхийг анхаарах;

-Уурхайн ашиглалтын жил, олборлолтын гүнээс хамааруулан, шүүрлийн усны тооцооллыг жил жилээр хийх;

15. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм"-ын дагуу тооцоход үйлдвэрлэлийн хэрэгцээнд:

$$16,090.0\text{м}^3 \times 3.8\text{м}^3 = 61,142.0\text{м}^3 \text{ ус шаардлагатай.}$$

Баяжуулах үйлдвэр нь 70тн/цаг хүчин чадалтай.74

Баяжуулах үйлдвэрт ашиглах нийт усны 70%-ийг эргэлтээр 30%-ийг нөхөн сэлбэлтээр авна. (ТЭЗҮ 74-р хуудас)

$61,142.0\text{м}^3 \times 0.3 = 18,342.6\text{м}^3$	-Баяжуулах үйлдвэр нөхөн сэлбэлтээр авах нийт усны хэмжээ
$28,611.0\text{м}^2 \times 2\text{л}/\text{м}^2 \times 90\text{хон} = 5,149.9\text{м}^3$	-Зам талбайн тоосжилт дарахад шаардагдах усны хэмжээ
$1000\text{ш}/\text{мод} \times 40.0\text{л}/\text{ш} \times 9 \text{ удаа} = 360.0\text{м}^3$	-“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ний хүрээнд мод усалгаанд ашиглах усны хэмжээ
$23.2\text{м}^3/\text{хон} \times 207\text{хон} = 4,802.4\text{м}^3$	-Уурхайд орж ирэх шүүрлийн усны хэмжээ (БОННҮТ 63-р хуудас)
$5,149.9\text{м}^3 - 4,802.4\text{м}^3 = 347.5\text{м}^3$	Зам талбайн тоосжилт дарахад газрын доорх уснаас ашиглах хэмжээ
$18,342.6\text{м}^3 + 4,802.4\text{м}^3 + 347.5\text{м}^3 + 360.0\text{м}^3 = 23,852.5\text{м}^3$	-Нийт ашиглах усны хэмжээ
$71\text{хүн} \times 150\text{л}/\text{хон} \times 207\text{хон} = 2,204.5\text{м}^3$	-Ажиллагсдын унд ахуйн усны хэрэгцээ



16. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу ногдуулах усны төлбөрийн хэмжээ

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу унд, ахуйн зориулалтаар ашиглах **2,204.5м³** усыг төлбөрөөс чөлөөлнө.

Уурхайд орж ирэх **4,802.4м³** шүүрлийн ус, ашигт малтмал баяжуулахад ашиглах **18,342.6м³**, зам талбайн тоосжилт дарахад ашиглах **347.5м³**, биологийн нөхөн сэргээлтэд ашиглах **360.0м³** усыг усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Хараа голын сав газарт тогтоосон экологи-эдийн засгийн суурь үнэ, 2013 оны 326, 327 дугаар тогтоолоор баталсан, ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тус тус үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

Шавхан зайлуулах газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$$1\text{м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 2,764\text{төг/м}^3 \times 0.15 \times 1.4 = 580.44 \text{ төг/м}^3$$

2,764төг/м³ – Хараа голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;

(15%) – 326-р тогтоолын 7(в)-д газрын доорх усыг шавхан зайлуулсныг тооцох төлбөрийн хувь, хэмжээ;

1.4 – Газрын доорх усыг шавхан зайлуулсныг тооцох итгэлцүүр;

$$4,802.4\text{м}^3 \times 580.44 \text{ төг/м}^3 = \mathbf{2,787,505.05 \text{ төг}}$$

Ашигт малтмал баяжуулахад газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$$1\text{м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 2,764\text{төг/м}^3 \times 0.2 \times 1.4 = 773.92 \text{ төг/м}^3$$

2,764төг/м³ – Хараа голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;

(20%) – 326-р тогтоолын 7(а)-д заасан ашигт малтмал баяжуулахад газрын доорх ус ашигласныг тооцох төлбөрийн хувь, хэмжээ;

1.4 – Ашигт малтмал баяжуулахад газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр;

$$18,342.6\text{м}^3 \times 773.92 \text{ төг/м}^3 = \mathbf{14,195,704.9 \text{ төг}}$$

Зам талбайн тоосжилт дарахад газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$$1\text{м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 2,764\text{төг/м}^3 \times 0.2 \times 0.3 = 165.84 \text{ төг/м}^3$$

2,764төг/м³ – Хараа голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;

(20%) – 326-р тогтоолын 4-т заасан зам талбайн тоосжилт дарахад газрын доорх ус ашигласныг тооцох төлбөрийн хувь, хэмжээ;

0.3 – Зам талбайн тоосжилт дарахад газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр;

$$347.5\text{м}^3 \times 165.84 \text{ төг/м}^3 = \mathbf{57,629.4 \text{ төг}}$$

Биологийн нөхөн сэргээлтэд газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$$1\text{м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 2,764\text{төг/м}^3 \times 0.1 \times 0.25 = 69.1 \text{ төг/м}^3$$

2,764төг/м³ – Хараа голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;

(10%) – 326-р тогтоолын 9-д биологийн нөхөн сэргээлтэд газрын доорх ус ашигласныг тооцох төлбөрийн хувь, хэмжээ;

0.25 – Биологийн нөхөн сэргээлтэд газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр;

$$360.0\text{м}^3 \times 69.1 \text{ төг/м}^3 = \mathbf{24,876.0 \text{ төг}}$$

Нийт төлбөр: 2,787,505.05 төг + 14,195,704.9 төг + 57,629.4 төг + 24,876.0 төг =
17,065,715.8 төг

(Арван долоон сая жаран таван мянга долоон зуун арван таван төгрөг)



17. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар

-Хаягдал бохир усыг стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, цэвэрлэсэн усаа зам, талбайн тоос дарах болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах;
-Уурхайд орж ирэх шүүрлийн усыг бүрэн эргүүлэн ашиглах;

18. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Хараа-Ерөө голын сав захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулах;
- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах;
- Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх.
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны нөөц ашигласны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах.
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус татах шугам хоолой бүрт баталгаажуулсан тоолуур суурилуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх;
- Хаягдал усны дүгнэлтийг тухайн жилийн эхний улиралд багтаан гаргуулах;
- Үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед Сав газрын захиргаа болон холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж ирүүлэх;
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2022 оны 12 дугаар сарын 20-ны дотор Усны газарт office@water.gov.mn цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах;



УС АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ДАРХАНЧИМЭГ

УС АШИГЛАЛТЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.НАМНАНДОРЖ



ХАРАА-ЕРӨӨ ГОЛЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/30

Дархан

Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын “Усны тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 128 тоот ус ашиглуулах дүгнэлт, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших Цагаан чулуутын алтны үндсэн ордыг далд уурхайн аргаар ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сэлэнгэ аймаг Баянгол сум “Цагаан чулуут” байрлах алтны үндсэн ордыг далд аргаар олборлон, гравитацийн аргаар баяжуулах, үйл ажиллагаа явуулж буй “Хонгорын орд” ХХК-нд 2022 онд унд ахуйн хэрэглээнд $2,204.5\text{ м}^3$, үйлдвэрлэлийн хэрэгцээнд $23,852.0\text{ м}^3$, нийт $26,057\text{ м}^3$ усыг Хараа голын сав газраас авч ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. “Усны тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1-д тус тус заасны дагуу “ус ашиглах” гэрээ байгуулж, энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 28 дугаар зүйлийн 28.7, 28.18, 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь заалт болон ус ашиглахад тавигдах шаардлага, эрх үүргийг мөрдөж ажиллах, улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдуулан, 2022 оны ус ашиглалтын тайланг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хараа-Ерөө голын сав газрын Захиргаанд ирүүлэн, гэрээг дүгнүүлэхийг “Хонгорын орд” ХХК-ний захирал Ж.Ганболд-д даалгасугай.


3. Тушаалын хэрэгжилт болон уурхайн технологийн ус ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Засаг дарга, Байгаль орчны хяналтын Улсын байцаагч, Байгаль хамгаалагч нарт зөвлөсүгэй.

Хавсралт 4 хуудастай.

ДАРГА



Ө.АРИУНБААТАР



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2022 оны 06 сарын 15-ны өдөр

Дугаар № 19

Дархан-Уул аймаг

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 29.1-д заасны Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2022 оны 06 дугаар сарын 07-ний өдрийн 128 тоот ус ашиглуулах дүгнэлт, Хараа-Ерөө голын сав газрын захиргаанаас олгосон 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/30 тоот ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн: Усны нөөц ашиглуулагчийг төлөөлж Хараа-Ерөө голын сав газрын Захиргааны Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Оюунгэрэл, Ус ашиглагчийг төлөөлж Сэлэнгэ аймаг Баянгол сум, Цагаан чулуутад байрлах 9011107085 тоот улсын бүртгэлийн дугаартай, 2577453 регистрийн дугаартай, MV-016982 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Хонгорын орд" ХХК-ний геологич ажилтай Д.Энхмэнд нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 2022 оны 12 сарын 31-ний өдөр хүртэл /207 хоног/ хугацаатайгаар байгуулав.

1.2. Гэрээг монгол хэлээр 3% үйлдэж талуудад нэг нэг хувь хадгалагдах бөгөөд аль ч хувь нь хуулийн хүчинтэй баримт мөн.

1.3. Энэхүү гэрээнд тусгагдаагүй зүйлийг Монгол Улсын холбогдох хуулиар зохицуулна.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. **Ус ашиглах зориулалт:** Унд ахуй, баяжуулах технологи, зам талбайн тоосжилт дарах зориулалтаар уурхайн шүүрлийн ус болон гүний худгийн уснаас хангана. 2022 онд 16090м³ элс олборлон 67.4кг алт авахаар төлөвлөсөн байна. "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ний хүрээнд 1000ш мод тарина.

2.2. **Нийт ашиглах усны хэмжээ:** - 23.852,5 м³ /жил

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм"-ын дагуу тооцоход үйлдвэрлэлийн хэрэгцээнд:

$$16,090.0\text{м}^3 \times 3.8\text{м}^3 = 61,142.0\text{м}^3 \text{ ус шаардлагатай.}$$

Баяжуулах үйлдвэр нь 70тн/цаг хүчин чадалтай.

Баяжуулах үйлдвэрт ашиглах нийт усны 70%-ийг эргэлтээр 30%-ийг нөхөн сэлбэлтээр авна.

(ТЭЗҮ 74-р хуудас)

$61,142.0\text{м}^3 \times 0.3 = 18,342.6\text{м}^3$	-Баяжуулах үйлдвэр нөхөн сэлбэлтээр авах нийт усны хэмжээ
$28,611.0\text{м}^2 \times 2\text{л/м}^2 \times 90\text{хон} = 5,149.9\text{м}^3$	-Зам талбайн тоосжилт дарахад шаардагдах усны хэмжээ
$1000\text{ш/мод} \times 40.0\text{л/ш} \times 9 \text{ удаа} = 360.0\text{м}^3$	-“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ний хүрээнд мод усалгаанд ашиглах усны хэмжээ
$23.2\text{м}^3/\text{хон} \times 207\text{хон} = 4,802.4\text{м}^3$	-Уурхайд орж ирэх шүүрлийн усны хэмжээ (БОННҮТ 63-р хуудас)
$5,149.9\text{м}^3 - 4,802.4\text{м}^3 = 347.5\text{м}^3$	Зам талбайн тоосжилт дарахад газрын доорх уснаас ашиглах хэмжээ
$18,342.6\text{м}^3 + 4,802.4\text{м}^3 + 347.5\text{м}^3 + 360.0\text{м}^3 = 23,852.5\text{м}^3$	-Нийт ашиглах усны хэмжээ
$71\text{хүн} \times 150\text{л/хон} \times 207\text{хон} = 2,204.5\text{м}^3$	-Ажиллагсдын унд ахуйн усны хэрэгцээ

2.3. Усны чанар, найрлага: Унд ахуйн болон үйлдвэрийн технологийн усыг өөрийн эзэмшлийн 3,6л/сек ундаргатай гүний худгаас хангана. Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвөөр гидрохимийн шинжилгээ хийлгэж, лабораторийн дүгнэлтийг Хараа Ерөө голын сав газрын захиргаанд улирал тутамд ирүүлнэ.

2.4. Усны эх үүсвэрийн байршил: Унд ахуйн хэрэгцээт усыг гүний худгаас, технологи болон зам талбайн усалгаа, бирлогийн нөхөн сэргээлтэд ашиглах усыг шүүрлийн ус болон гүний худгаас хангана. Хоногт унд ахуйн хэрэгцээнд $10.65 \text{ м}^3/\text{хон ус}$ хэрэглэнэ.

2.5. Усны барилга байгууламж: Нийт 5.8л/сек ундаргатай 2ш гүний худагтай. Эргэлтийн усан сангийн эзлэхүүн 400м^3 , хаягдлын сангийн эзлэхүүн 2000м^3 байна.

№	Солбилцол	Тоолуурын марк	Насосын марк	Худгийн ундарга
1.	106'25'41.6" 49'08'71.6"	LXSG-25	FROS-5QJ	3.6л/сек
2.	106'25'57.20" 49'07'23.86"	LXSG-40	FROS-5QJ	2.2л/сек

2.6. Дамжуулах байгууламж: Гүний худгаас эргэлтийн усан санд $\phi=30\text{мм}$ голчтой 30м урттай хоолой суурилуулсан.

2.7. Хаягдал усны хэмжээ цэвэрлэгээний арга: Ахуйн бохир усыг хөрсөнд нэвчүүлэн зайлуулна.

2.8. Байгаль орчны үнэлгээ нөхцөл: "Цагаан чулуут" алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг 2019 онд "Ашид ананда" ХХК хийж гүйцэтгэсэн.

2.9. Онцгой нөхцөл: Хаягдал усны холимог сорьц авч байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж хариу дүнг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор сав газрын захиргаанд ирүүлэхийг анхаарч ажиллах;

Хаягдлын сангийн ажлын зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж дүгнэлтийг зураг төслийн дүгнэлтийг ирүүлэх,

Уурхайн ашиглалтын жил, олборлолтын гүнээс хамааруулан, шүүрлийн усны тооцооллыг жил жилээр хийх;

2.10. Ус ашигласны төлбөрийн хэмжээ:

Монгол Улсын "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай" хуулийн 20.1.1-д заасны дагуу унд ахуйд жилд ашиглах $2,204.5\text{м}^3$ усыг төлбөрөөс чөлөөлнө.

Уурхайд орж ирэх $4,802.4\text{м}^3$ шүүрлийн ус, ашигт малтмал баяжуулахад ашиглах $18,342.6\text{м}^3$, зам талбайн тоосжилт дарахад ашиглах 347.5м^3 , биологийн нөхөн сэргээлтэд ашиглах 360.0м^3 усыг усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Хараа голын сав газарт тогтоосон экологи-эдийн засгийн суурь үнэ, 2013 оны 326, 327 дугаар тогтоолоор баталсан, ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тус тус үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

Шавхан зайлуулах газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

1 м^3 газрын доорх усны үнэ: $2,764\text{төг}/\text{м}^3 \times 0,15 \times 1,4 = 580.44 \text{ төг}/\text{м}^3$, $2,764\text{төг}/\text{м}^3$ - Хараа голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;
(15%) - 326-р тогтоолын 7(в)-д газрын доорх усыг шавхан зайлуулсныг тооцох төлбөрийн хувь, хэмжээ;
1.4 - Газрын доорх усыг шавхан зайлуулсныг тооцох итгэлцүүр;

$$4,802.4\text{м}^3 \times 580.44 \text{ төг}/\text{м}^3 = 2,787,505.05 \text{ төг}$$

Ашигт малтмал баяжуулахад газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

1 м^3 газрын доорх усны үнэ: $2,764\text{төг}/\text{м}^3 \times 0,2 \times 1,4 = 773.92 \text{ төг}/\text{м}^3$
 $2,764\text{төг}/\text{м}^3$ - Хараа голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;
(20%) - 326-р тогтоолын 7(а)-д заасан ашигт малтмал баяжуулахад газрын доорх ус ашигласныг тооцох төлбөрийн хувь, хэмжээ;
1.4 - Ашигт малтмал баяжуулахад газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр;

$$18,342.6\text{м}^3 \times 773.92 \text{ төг}/\text{м}^3 = 14,195,704.9 \text{ төг}$$


4.5.2. Аль нэг тал нь татан буугдсан.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

Усны нөөц ашиглуулагчийг төлөөлж:

ХЕГСГЗ-ны Уул уурхай, эрчим хүчний
ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн



Г.Оюунгэрэл

ХАЯГ:

Дархан-Уул аймаг, Дархан сумын 14-р баг,

Монгол банкны 3 давхарт


Хараа-Ерөө голын сав газрын захиргаа

Утас-70373171

99115990, 99370937

Ус ашиглагчийг төлөөлж:

Сэлэнгэ аймаг, Баянгол сум
“Хонгорын орд” ХХК-ний геологи



Д.Энхмэнд

ХАЯГ:

Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг 15-р

хороо Жаргалант хотхон 4-р байр-09 тоот

Утас -99093846, 99154223

Шилжүүлгийн мэдээлэл

Журналын №: 78391672

Системийн огноо: 2022.10.28

Нэр: БЛУ ГОЛД ИНВЕСТМЕНТ ХХК

Илгээгч	Дансны дугаар:	Нэр	Дүн	Ханш
	410048901	БЛУ ГОЛД ИНВЕСТМЕНТ ХХК	4,213,840.00 MNT	1.00
/ дөрвөн сая хоёр зуун арван гурван мянга найман зуун дөчин төгрөг /				
Хүлээн авагч	Банкны дугаар:	Банкны нэр	4,213,840.00 MNT	1.00
	04	Худалдаа Хөгжлийн Банк		
	Дансны дугаар	Нэр		

Гүйлгээний утга:

ЕВ -3221004833181-Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр-С

Танд баярлалаа

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан

Салбар, тооцооны төв:

Гарын үсэг: Банк


Нархан

Тамга: салбар

Огноо: Он Сар Өдөр

2022-10-28

БАТЛАВ



ХОГ ХАЯГДАЛЫН ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ

Баянгол сум

2022.01.02

ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

Монгол Улсын Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад гарсан ахиун хог хаягдлыг цаг хугацаанд нь шуурхай тээвэрлэж, цэвэрхэн эрүүл орчин бүрдүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

ГЭРЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын 2007 оны 18 дугаар тогтоол, Монгол Улсын "Ариун цэврийн тухай" хуулийн 7.4, 17.1.4 дэх заалт Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 20 тоот тогтоолыг тус тус үндэслэн нэг талаас Баянгол сумын Засаг даргын тамгын газрыг төлөөлж нягтлан бодогч Батцэнгэл овогтой Сарантуяа, нөгөө талаас "ХОНГОРЫН ОРД" ХХК-ийн /ЦАГААН ЧУЛУУТЫН АЛТНЫ ҮНДСЭН ОРД/ менежер Дамбадаржаа овогтой Энхмэнд нар харилцан тохиролцож 2022 оны 01 дүгээр сарын 02-нээс 2022 оны 12 сарын 31-ны өдрийн хүртэл хугацаатайгаар гэрээ байгуулав.

НЭГ. ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

Захиалагч нь өөрийн ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдалыг тогтоосон цаг хугацаанд тээвэрлэж байгаа эсэхэд хяналт тавьж, шаардлага тавих эрхтэй.

5. Монгол Улсын Хог Хаягдлын тухай хууль, Засгийн газрын 2007 оны 18 дугаар тогтоолыг үндэслэн хог хаягдал үүсгэсэний төлбөр сарын 100000 төгрөг, жилийн 1200000 төгрөгөөр тооцож сарын төлбөрийг тухайн сарын 05-ны дотор Сэ.Ба Хог хаягдлын хураамж 100130800947 тоот дансанд хийж байх.

6. Монгол Улсын "Ариун цэврийн тухай" хуулийн 7.4, 17.1.4 дэх заалтыг үндэслэн гадаад орчноо бохирдуулахгүй хог хаягдлыг төвлөрсөн цэгээс өөр газар хаяхгүй байх үүрэгтэй.

7. Захиалагч Монгол Улсын Хог хаягдлын тухай хуульд заасны дагуу орчны газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, устгах үүрэгтэй.

8. Тусгай эмнэлэгийн байгууллагын хог, цацраг идэвхит болон химийн хортой бодис үйлдвэрлэл, туршилт, шинжилгээний ажил хийх үед захилагч байгууллага нь гүйцэтгэгч байгууллагад урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭГИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5. Монгол Улсын Хог хаягдын тухай хуулийн 12 дугаар заалтыг үндэслэн аж ахуй нэгж байгууллага иргэдээс хог хаягдал гаргасаны төлбөрийг нэхэмжилэн авах эрхтэй.

6. Гүйцэтгэгч нь тухайн байгуулагатай байгуулсан гэрээний дагуу цаг хугацаанд нь зөөж тээвэрлэж, зайлуулж байх үүрэгтэй.

7. Тусгай хог хаягдлын Засгийн газрын 2006 оны 238 дугаар тогтоол, сумын ИТХ-ын баталсан журмын дагуу зөөж тээвэрлэж, зайлуулж байх үүрэгтэй.

8. Хог тээвэрлэлт, хог гаргасаны төлбөрийг заасан хугацаанд байгууллага, аж ахуй нэгж, иргэд барагдуулгүй тохиолдолд хоног тутмын 0,5 хувийн алданги тооцож ажиллана.

ГУРАВ. БУСАД ЗҮЙЛ

4. Өөрийн эзэмшлийн байшин барилга засварлах, буулгах тохиолдолд сумын хог хаягдлынсанд урьдчилан мэдэгдэж барилгын хог хаягдлаа тусад нь тээвэрлэнэ.

5. Тээврийн хөлсний тарифанд өөрчлөлт орсон тохиолдолд хоёр тал харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

6. Гэрээгээр хоёр тал харилцан бие биедээ хүндэтгэлтэй хандах ба маргаантай асуудлыг зөвшилцөлийн замаар шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэх боломжгүй болсон тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандаж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗДТГ-ЫГ ТӨЛӨӨЛЖ:

“ХОНГОРЫН ОРД” ХХК-ИЙН

НЯГТЛАН БОДОГЧ
/АЛБАН ТУШААЛ/

МЕНЕЖЕР
/АЛБАН ТУШААЛ/

БАТЦЭНГЭЛ ОВОГТОЙ САРАНТУЯА
ЭНХМЭНД

ДАМБАДАРЖАА ОВОГТОЙ

/ОВОГ НЭР/

/ОВОГ НЭР/

Сэлэнгэ аймгийн
Баянгол сумын
Засаг даргын байрны
газрын
САНХҮҮ
МБА0005

/ГАРЫН ҮСЭГ/

/ГАРЫН ҮСЭГ/

ХАРИЛЦАХ УТАС: 99889682

ХАРИЛЦАХ УТАС: 99154223

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ

№	Байршил	Хүний тоо
1	/ЦАГААН ЧУЛУУТЫН АЛТНЫ ҮНДСЭН ОРД	15
	Нийт дүн	15

Шилжүүлгийн мэдээлэл

Журналын №: 65267274

Системийн огноо: 2022.06.27

Нэр: **БЛҮ ГОЛД ИНВЕСТМЕНТ ХХК**

Илгээгч	Дансны дугаар: 410048901	Нэр БЛҮ ГОЛД ИНВЕСТМЕНТ ХХК	Дүн 1,200,000.00 MNT	Ханш 1.00
/ нэг сая хоёр зуун мянган төгрөг /				
Хүлээн авагч	Банкны дугаар: 040000	Банкны нэр Худалдаа Хөгжлийн Банк	1,200,000.00 MNT	1.00
	Дансны дугаар	Нэр		

Гүйлгээний утга:

ЕВ -2220602529176-Хог хаягдлын үйлчилгээний хураамж-Сэлэнгэ

Танд баярлалаа

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан

Салбар, тооцооны төв:

Гарын үсэг:

Тамга:

Огноо: _____ Он ____ Сар ____ Өдөр



XABCPAJT

Төсөл хэрэгжүүлэгч: “Хонгорын орд” ХХК

*Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших
“Хонгорын орд” ХХК-ийн MV-016982 тоот
ашиглалын тусгай зөвшөөрөлтэй “Цагаан чулуутын
алтны үндсэн орд”-ыг далд аргаар ашиглах төслийн
байгаль орчны хяналт шинжилгээний тайлан*

2022 он

ГАРЧИГ

1.	ОРШИЛ.....	3
2.	ЦАГААН ЧУЛУУТ АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ.....	4
2.1.	АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ	6
2.1.1	Судалгааны зорилго	6
2.1.2	Судалгааны байршил, хамрагдсан цэгүүд.....	6
2.1.3	Судалгааны арга, дээж авалт	6
2.1.4	Судалгаанд ашигласан багаж хэрэгсэл.....	7
2.1.5	Хяналт шинжилгээний дүн.....	7
2.1.5.1	Агаарын бохирдуулагч бодисын хэмжилт.....	8
2.1.5.2	Дуу шуугианы хэмжилт	8
2.1.6	Дүгнэлт, зөвлөмж.....	9
2.2.	Хөрсний хяналт-шинжилгээ.....	9
2.2.1	Хөрсний мониторингийн судалгаа.....	10
2.2.2	Лабораторийн шинжилгээний дүн.....	13
2.2.3	Дүгнэлт	18
2.2.4	Санал	18
2.3.	Усны хяналт шинжилгээ	18
2.3.1	Гүний усны хяналт-шинжилгээний үр дүн	19
2.3.2	Хаягдал усны хяналт-шинжилгээний үр дүн.....	19

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Агаарын чанарын хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил.....	6
Хүснэгт 2.	Нийт тоос / Нийт жинлэгдэгч бодис / хэмжилтийн үр дүн	7
Хүснэгт 4.	Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн	8
Хүснэгт 5.	Дуу шуугианы хэмжилтийн үр дүн	8
Хүснэгт 6	“Цагаан Чулуут” талбайн хөрсний дээжлэлтийн солбицол.....	9
Хүснэгт 7	Хөрсний чийгийн хөдлөл зүй (мониторинг).....	12
Хүснэгт 8	Мониторингийн судалгаа хийсэн байгалийн тогтоцоороо байгаа хөрсний агрохимийн харьцуулсан үндсэн үзүүлэлтүүд.....	13
Хүснэгт 9	Хөрсний хүнд металл.....	16
Хүснэгт 10	Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ.....	17
Хүснэгт 11	Усны чанарын хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил	18
Хүснэгт 12	Усны ерөнхий химийн шинжилгээ – Худагаас	19
Хүснэгт 13	Хаягдал усны химийн шинжилгээ - Хаягдлын сан.....	20

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Талбайн ерөнхий байршилын зураг	3
Зураг 2 Орчны хяналт шинжилгээ хийх ажлын явц	4
Зураг 3 Мониторингийн судалгаа хийсэн баримт материалын зураг	5
Зураг 4 . DustTrak 8530 загварын зөөврийн багаж.....	7
Зураг 5. EXTECH Noise Dosimeter, Datalogger, and Sound Level Meter SL355 загварын зөөврийн багаж	7
Зураг 6. Хөрсний зүсэлтийн байршилын зураг	9
Зураг 7. “Цагаан чулуут” талбайн холимог ой, ойн ширэгт бараан хөрс. А.Энхтөр. 2022.IX.6..	10
Зураг 8. “Цагаан чулуут” талбайн уулын өвөр хэсэг, баруун энгэр, хүрэн хөрс. А.Энхтөр. 2022.IX.6	11
Зураг 9. “Цагаан чулуут” талбайд газрын хөрсний бохирдол,	12
Зураг 10. Хаягдал усны далангийн шорооны хүнд металлын байдал. А.Энхтөр. 2020.IX.6.	12

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ


График 1. Үйлдвэрийн салхин дээр болон үйлдвэрийн салхин доороос авсан агаарын чанарын 2 цэгийн нийт тоосонцрын агууламж	7
График 2. Үйлдвэрийн салхин дээр болон үйлдвэрийн салхин доороос авсан агаарын чанарын 2 цэгийн азотын давхар исэл, хүхэрлэг хийн агууламж.....	8
График 3.2021, 2022 онд судалсан ойн бараан ба уулын хүрэн хөрсний чийгийн хөдлөлзүй	13
График 4. 2021, 2022 онд судалсан ойн бараан хөрсний агрохимийн харьцуулсан үзүүлэлт.....	14
График 5. 2021, 2022 онд судалсан уулын хүрэн хөрсний агрохимийн харьцуулсан үзүүлэлт ..	15
График 6. 2021, 2022 онд судалсан хөрсний хүнд металлын харьцуулсан үзүүлэлт	16
График 7. Хаягдал усны далангийн шорооны хүнд металл, 2022 онд анх судалсан.....	17

1. ОРШИЛ

“Хонгорын орд” ХХК нь Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Цагаан чулуут” нэртэй 84,49 га талбай бүхий MV-016982 дугаартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2002 оны 9-сарын 02-нд АМХЭГ-ын ГУУКА-аас авсан.

“Хонгорын орд” ХХК нь 2022 онд дээрх тусгай зөвшөөрөлт талбайд ашиглалтын үйл ажиллагаа явуулагүй ч 2020 онд овоолго үүсгэсэн 4000 гаруу тн хүдрийг боловсруулах, гравитацийн бага оврын үйлдвэр барих, гидрогеологийн судалгаа хийх, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн хүрээнд байгаль орчны хяналт шинжилгээний ажлын тайланд агаар орчин, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрвч гэсэн чиглэлээр хээрийн болон суурин судалгаа хийж, хяналт шинжилгээний цэгийг тогтоосноор анхны үзүүлэлтэй харьцуулан үнэлэлт дүгнэлт өгч, төслийн талбайн олон жилийн судалгааны мэдээ материал үүсэж, байгаль орчны тогтвортой байдлыг хангах үндэслэлтэй.



Зураг 1 Талбайн ерөнхий байршиллын зураг

2. ЦАГААН ЧУЛУУТ АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ


Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд “Цагаан чулуут” ашиглалтын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг үнэлэх, байгаль орчны хяналт шинжилгээний судалгааг 2022 оны 4 сарын 10-өдрөөс 9 дүгээр сарын 20-ны хоорондох хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Байгаль орчны хяналт, шинжилгээний ажлыг дараах баг судлаачдын баг ажиллалаа. Багийн бүрэлдэхүүнд:

- Хөрс судлаач: А.Энхтөр
- Агаарын чанарын судлаач: Б.Батхишиг
- Усны шинжээч: Д.Оюунчимэг
- Хээрийн судалгааны ажиглагч, дээж авагч Д.Энхмэнд нар хийж гүйцэтгэлээ.



Зураг 2 Орчны хяналт шинжилгээ хийх ажлын явц



Зураг 3 Мониторингийн судалгаа хийсэн баримт материалын зураг


2.1. Агаарын чанарын хяналт-шинжилгээ

2.1.1 Судалгааны зорилго

“Цагаан чулуутын алтны үндсэн орд”-ыг далд аргаар ашиглах төслийн 2022 онд хэрэгжүүлсэн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн мониторинг судалгаагаар агаарын чанарын хяналт шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорьсон.

2.1.2 Судалгааны байршил, хамрагдсан цэгүүд

Хүснэгт 1. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил

№	Агаар	Координат	Цэг сонгосон үндэслэл	Дээж авч буй фото зураг
1	1-р цэг үйлдвэрийн салхин дээр	49° 8'42.71"N 106°25'25.56"E	2022 оны БОМТ-нд тусгагдсан хяналт шинжилгээний цэг	
2	2-р цэг үйлдвэрийн салхин доор	49° 8'41.93"N 106°25'24.96"E		

2.1.3 Судалгааны арга, дээж авалт

Төслийн талбай орчим болон үйлдвэрийн салхин доор гэсэн хоёр цэгт агаарын хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), нийт тоос (нийт жинлэгдэгч бодис) болон дуу шуугиан үзүүлэлт тус бүрийг хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнгээр тодорхойлов. Үүнд:

- **Хүхэрлэг хий болон азотын давхар исэл:** Хүхэрлэг хий болон азотын давхар ислийг тодорхойлохдоо химийн шинжилгээний аргачлалаар тодорхойлсон.
 - **Хүхэрлэг хий:** Агаараас тетрахлормеркурат натрийн уусмал /ТХМ/-аар норгосон шингээгч гуурсанд 2 л/мин хурдтайгаар 20 минутын турш агаараас сорьц авч шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргад шингэсэн хүхэрлэг хийг лабораторийн нөхцөлд усан уусмалд шилжүүлж тэр уусмал дээрээ формальдегид, парарозаналины уусмал нэмэхэд үүссэн нэгдлийн өнгөний эрчимшлийг спектрофотометрээр хэмжин хүхэрлэг хийн агууламжийг тодорхойлов.
 - **Азотын давхар исэл:** Агаараас азотын давхар ислийг үл хатах мышьяклаг хүчлийн натрийн давс агуулсан кали иодын уусмалаар норгосон шингээгч гуурсаар 0.25 л/мин-ын хурдтайгаар 20 минутын турш соруулан сорьц авч шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргаанд шингээж лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж үүссэн нитрит ион сульфаналины хүчилтэй харилцан үйлчилж diaзонэгдлийг үүсгэх бөгөөд тэр нь -нафтиламинтай урвалд орж азобудагч бодисыг уусмалын өнгөний эрчимшлээр азотын давхар ислийн хэмжээг тодорхойлов.
- **Нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис):** Төслийн талбай орчмын агаарт агуулагдах нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис)-ны агууламжийг DustTrak 8530 зөөврийн багажийн тусламжтай тодорхойлсон.
- **Дуу чимээ:** Шуугианы хэмжилтийг MNS 5003:2000 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага.”

стандарт аргачлалын дагуу EXTECH Noise Dosimeter, Datalogger, and Sound Level Meter SL355) загварын зөөврийн багажаар тодорхойлсон.

2.1.4 Судалгаанд ашигласан багаж хэрэгсэл



Зураг 4. DustTrak 8530 загварын зөөврийн багаж



Зураг 5. EXTECH Noise Dosimeter, Datalogger, and Sound Level Meter SL355 загварын зөөврийн багаж

2.1.5 Хяналт шинжилгээний дүн

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан нийт тоосны хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас даваагүй, хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 2. Нийт тоос / Нийт жинлэгдэгч бодис / хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	Нийт тоос /Нийт жинлэгдэгч бодис/ мкг/м ³
1	Үйлдвэрийн салхин дээр	0.115
2	Үйлдвэрийн салхин доор	0.065
Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016		0.500



График 1. Үйлдвэрийн салхин дээр болон үйлдвэрийн салхин доороос авсан агаарын чанарын 2 цэгийн нийт тоосонцорын агууламж

2.1.5.1 Агаарын бохирдуулагч бодисын хэмжилт

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан хүхэрлэг хий болон азотын давхар ислийн хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт илрээгүй хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 3. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	NO ₂	SO ₂
		(Азотын давхар исэл мг/м ³)	(Хүхэрлэг хий мг/м ³)
1	Үйлдвэрийн салхин дээр	0.027	0.009
2	Үйлдвэрийн салхин доор	0.025	0.10
Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016		0.200	0.450



График 2. Үйлдвэрийн салхин дээр болон үйлдвэрийн салхин доороос авсан агаарын чанарын 2 цэгийн азотын давхар исэл, хүхэрлэг хийн агууламж

2.1.5.2 Дуу шуугианы хэмжилт

Дуу шуугианы үзүүлэлтийг хяналтын 2 цэгийн ойр орчимд хэмжсэн ба үр дүнг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад уурхайн талбайн ойролцоо зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна.

Хүснэгт 4. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	Дуу чимээ дБ (А)
1	Үйлдвэрийн салхин дээр	45
2	Үйлдвэрийн салхин доор	43
Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016 дБ (А), 16 цагийн дундаж		60

2.1.6 Дүгнэлт, зөвлөмж

Төслийн талбай орчим болон үйлдвэрийн салхин доор гэсэн хяналтын 2 цэгээс агаарын хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис) болон дуу шуугиан хэмжилт хийж гарсан үр дүн тус бүрийг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна.

2.2. Хөрсний хяналт-шинжилгээ

Ашиглалтын талбайд хөрсний мониторингийн судалгааг хийлээ. Тус талбайн болон тэнд хөрсний зүсэлт хийсэн цэгүүдийн газарзүйн солбицолын тоон угта, өндөршлийг хүснэгтээр харуулав. Өөрөөр хэлбэл 2021 оны судалгааны байршил болон цэгүүдэд өөрчлөлт байхгүй.

Хүснэгт 5 “Цагаан Чулуут” талбайн хөрсний дээжлэлтийн солбицол

№	Дээжний нэр	Өргөрөг	Уртраг	Өндөршил
1	Хөрсний зүсэлт 1 (h1)	49° 09' 06.5”	106° 25' 31.7”	1176
2	Хөрсний зүсэлт 2 (h2)	49° 08' 47.5”	106° 25' 20.4”	1092
3	Хөрсний бохирдол (Зураг9)	49° 08' 42.05”	106° 25' 21.93”	1050
4	Хаягдал усны далангийн шороо (Зураг 10)	49° 08' 40.33”	106° 25' 22.20”	1048
Таних тэмдэг		1-4 – Талбайн солбицолын цэг, дугаар		
		h1,2 – Хөрсний зүсэлт, түүний дугаар		



Зураг 6 Хөрсний зүсэлтийн байршилын зураг

Тодруулвал, талбайн хойт тал нь 2 ба 3-р цэгт, урд тал нь 1 ба 4-р цэгт тус тус байрлаж байгаа бөгөөд далайн түвшинээс дээш (ДТД) 1076-1140 м-т байна. Хөрсний зүсэлт 1-ийг судалгаанд хамрагдсан талбайн хойшоо харсан арын хэсэгт холимог ой тархсан газарт газарзүйн солилцоолын 49° 09' 06.5” 106° 25' 31.7” угтад ДТД 1172 м-ийн

өндөрлөг газарт, зүсэлт 2 нь талбайн урд энгэрт газарзүйн солибцолын $49^{\circ} 08' 47.5''$, $106^{\circ} 25' 20.4''$ утгад байгаа.

Судлагдсан талбай экосистем, ландшафтын хувьд ойт хээрийн бүсэд хамрагдах уул бөгөөд ардаа холимог ойтой, өвөр хэсэг нь уулын хээр нутаг. Газарзүйн байршилын хувьд рельеф хүчтэй илэрсэн, налуу нь 6° - 40° байна. Хамгийн өндөр цэг талбайн хойт хэсэгт ДТД 1179 м, харин нам цэг нь талбайн баруун урд хэсэгт ДТД 1044 м-ын өндөрт оршиж байна. GPS багаж болон “Google Earth Pro” программ ашиглаж талбайн болон хөрсний зүсэлт хийсэн цэгүүдийг байршуулав. Нийт хэмжээ 84,5 га. Талбайгаас алт олборлоогүй, нөөцийн судалгааг талбайн хойт захын дунд, мөн зүүн болоод урд захад цэгэн байдлаар хийсэн. Зурагт цагаан шаргал өнгөөр дүрслэгдэн харагдана (Зураг 6).

Зургаас харахад талбайн хойт захад нарс болон хус мод ургасан холимог ой байгаа бөгөөд түүний талбайн хэмжээ 10,4 га. Эл ойтой талбайд ойн ширэгт бараан хөрс (таних тэмдэг h1) тархсан. Бусад талбай нь уулын өвөр хэсэгт хээрийн бүс нутагт хамрагдах газар. Тэнд уулын хүрэн хөрс (таних тэмдэг h2) 74,1 га ($84.5 - 10.4$) талбайд тогтворжсон байна (Зураг 6).

2.2.1 Хөрсний мониторингийн судалгаа

Судалгаанд хамрагдсан талбайн хойт захын ар хэсгийн нарс, хус модны холимог ойтой бөгөөд хөрсний зүсэлт хийсэн газарт ургамлын бүрхэвч 80-90%, улалж, сибир хялгана, соогон боролзгоно, нарс, хус зэрэг өвслөг болон модлог ургамал зонхилон ургажээ. Уулын арын 6-8⁰ налуутай холимог ойд ойн ширэгт бараан хөрс тархжээ.



Зураг 7 “Цагаан чулуут” талбайн холимог ой, ойн ширэгт бараан хөрс. А.Энхтөр. 2022.IX.6.

Ойн ширэгт бараан хөрс. Хөрс тархсан газрын нэр, зүсэлт хийсэн цэгийн газарзүйн солбицол болон хөрсний зүсэлтийг Хүснэгт 5, Зураг 6 ба 7-т харуулав.

Хөрсний бичиглэл. “А” давхаргын зузаан 27 см, “АВ” давхаргынх 17 см, үржил шимт давхарга нийт 44 см байна. Ширэгт давхарга нь 6-8 см байна (Зураг 7).

Давхарга Аш. 0-8 см. Хар саарал өнгөтэй, ургамлын үлдэгдэл, ширэлдсэн үндэс, түүний зай завсарт шороо чигжигдсэн бөгөөд цогцоор нь харахад зөөлөн хөвсгөр үе давхарга ажиглагдаж байна. Шилжилт өнгөөр тодорхой.

Давхарга А. 8-27 (19)см, хар бараан өнгөтэй, бат бөх бус үрлэн-бөөмөн бүтэцтэй, хөнгөн шавранцар, чийглэг, нягт (1.11 г/см^3), ургамлын үндсээр баялаг, давсны хүчилд бургихгүй, карбонат байхгүй, доош ухахад хялбар, хад чулуу байхгүй, шилжилт өнгөөр аажим.

Давхарга АВ. 27-44 (17)см, шаргалдуу бараан өнгөтэй, үрлэн-бөөмөн бүтэцтэй, жижиг үйрмэг чулуу (<10%) бага, хөнгөн шавранцар, чийглэг, нягт (1.12 г/см^3), ургамлын үндэс дунд зэрэг, давсны хүчилд хөөсрөхгүй байна, карбонатгүй, доош ухахад бэрхшээлгүй, том болон жижиг үйрмэг чулуу мэр сэр, шилжилт өнгөөр долгиолог хэлбэлзэлтэй.

Давхарга В. 44-64 (21) см, шаргал өнгөтэй, ургамлын үндэс бага, үрлэндүү-бөөмөрхөг бүтэцтэй, жижиг үйрмэг чулуу 10% орчим, хөнгөн шавранцар, чийгтэй, нягт (1.28 г/см^3), давсны хүчилд буржихгүй, карбонатгүй, том болон жижиг үйрмэг чулууны илрэл ажиглагдаж байна.

Уулын хүрэн хөрс. Зүсэлт хийсэн цэгийн газарзүйн солбицол болон хөрсний зүсэлтийг Хүснэгт 5, Зураг 6 ба 8-аас харна. Судалгаанд хамрагдсан талбайн өвөр хэсэгт уулын хээрийн бүс нутагт зонхилон ургадаг байгаль хялгана, түмэн навчит уртооз, яргуй, таван салаа зэрэг ургамал түгээмэл тархсан бөгөөд ургамлын бүрхэвч 75-85% байна. Уулын өвөр хэсгийн баруун зүгийн 9-11⁰ налуутай газарт энэхүү зүсэлтийг хийлээ (Зураг 7).



Зураг 8 “Цагаан чулуут” талбайн уулын өвөр хэсэг, баруун энгэр, хүрэн хөрс. А.Энхтөр. 2022.IX.6

Хөрсний бичиглэл. “А” давхаргын зузаан 23 см байна. Энэ нь тухайн хөрсний үржил шимт давхарга (Зураг 3).

Давхарга А. 0-23 (23)см, хүрэн өнгөтэй, бат бөх үрлэн-бөөмөн бүтэцтэй, хөнгөн шавранцар, чийглэг, нягт (1.24 г/см^3), ургамлын үндсээр баялаг, давсны хүчилд 18 см-ын гүнээс сул, 23 см-ын гүнээс хүчтэй бургиж байна. Үүнээс үзэхэд “А” давхаргын доод хэсгээс карбонат илэрч байна. Ухахад хялбар, хад чулуу мэр сэр тохиолдож байна, шилжилт өнгөөр тодорхой.

Давхарга Вк. 23-43 (20)см, шаргалдуу хүрэн өнгөтэй, үрлэн-бөөмөн бүтэцтэй, жижиг үйрмэг чулуу (10-20%) бага, хөнгөн шавранцар, чийглэг, нягт (1.28 г/см^3), ургамлынүндэс дунд зэрэг, давсны хүчилд хүчтэй хөөсөрч байна, карбонаттай, доош

ухахад бэрхшээлгүй, том болон жижиг үйрмэг чулуу тохиож байна, шилжилт өнгөөр тодорхой.

Давхарга ВСк. 43-57 (14) см, шаргал өнгөтэй, ургамлын үндэс бага, үрлэндүү-бөөмөрхөг бүтэцтэй, жижиг үйрмэг чулуу 20-30% орчим, хөнгөн шавранцар, чийгтэй, нягт (1.31 г/см³), давсны хүчилд хүчтэй бургиж байна, карбонаттай, том болон жижиг үйрмэг чулууны илрэл бий болж байна.

“Цагаан чулуут” хэмээх эл газар 2022 оноос эхлэн алт олборлож байна. Ийм учраас ажилчдын байр (кемп) бөгөөд алт ялгаж байгаа газраас хөрс бохирдсон буюу хөрсөнд агуулагдах хүнд металлын агууламж өөрчлөгдсөн эсэхийг тодорхойлох зорилгоор 90-100 см-ын гүнээс болон мөн алт олборлоход ашигласан хаягдал усны далангийн шорооноос дээж авлаа (Зураг 9, 10).



Зураг 9 “Цагаан чулуут” талбайд газрын хөрсний бохирдол,

Зураг 10 Хаягдал усны далангийн шорооны хүнд металлын байдал. А.Энхтөр. 2020.IX.6.

Зураг 9 цэгээс 2021 болон 2022 онд хоёр дахь удаагаа, алт ялгаж байгаа Зураг 10 цэгээс 2022 онд анх удаа хөрсний бохирдлын дээж авлаа. 2022 онд хөрсөнд агуулагдах чийгийн хэмжээг 2021 онд тодорхойлсон үзүүлэлттэй харьцуулж үзлээ (Хүснэгт 6).

Хүснэгт 6 Хөрсний чийгийн хөдлөл зүй (мониторинг)

№	Хөрсний нэр	Дээж авсан гүн, см	Хээрийн чийг,%
2021 оны хөрсний чийг			
1	Ойн бараан ширэгт хөрс	10-20	27,0
2		30-40	32,0
2022 оны хөрсний чийг			
3	Ойн бараан ширэгт хөрс	10-20	28,2
4		30-40	34,1
2021 оны хөрсний чийг			
5	Уулын хүрэн хөрс	10-20	21,9
6		30-40	25,5
2022 оны хөрсний чийг			
7	Уулын хүрэн хөрс	10-20	22,2
8		30-40	27,3
Таних тэмдэг (өнгөөр)		Ойн ширэгт бараан хөрс	
		Уулын хүрэн хөрс	




График 3.2021, 2022 онд судалсан ойн бараан ба уулын хүрэн хөрсний чийгийн хөдлөлзүй

Хүснэгт 2 болон график 3-аас үзэхэд 2021 болон 2022 онд ойн бараан ширэгт болон уулын хүрэн хөрсний чийгийн хэмжээнд мэдэгдэхүйц өөрчлөлт байхгүй байна. Тухайлбал Ойн бараа хөрсний 10-20 см-ын гүнд 27-28,2%-ийн чийгтэй байхад уулын хүрэн хөрсний мөн дээрх гүнд 21,9-22,2% байна. Ойн хөрсний чийгийн агууламж уулын хүрэн хөрснийхөөс ялимгүй их. Энэ нь ойд чийглэг, уулын өвөрт чийг бага байгааг нотолж байна. Ойт хээрийн бүс нутагт хөрсний доод үе давхарга, тодруулвал 30-40 см-ын гүнд хөрсний чийгийн агууламж дээд үе давхаргынхаас их байдаг зүй тогтол энд мөн ажиглагдаж байна. Үүнээс үзэхэд алт олборлож буй газар орчимд чийгийн илүүдэл ба дутагдал 2021-2022 онд ажиглагдахгүй байна. Дээрх чийгийн агууламж болон хөдлөл зүй нь хөрсний агрохимийн болон бусад үзүүлэлтүүдэд эерэг ба сөрөг нөлөө үзүүлэхгүй.

2.2.2 Лабораторийн шинжилгээний дүн

Ойн бараан (h1) ба уулын хүрэн (h2) хөрсөнд жил бүр мониторингийн судалгаа хийж байх учраас дээрх хоёр хөрсний зүсэлтээс авсан дээжүүдэд агрохимийн үзүүлэлтүүд, хүнд металлуудын агууламж болон эрүүл ахуйн шинжилгээний дээжийг давтан авч лабораторит тодорхойлуулав. 2021 оныхтой адилхан давтан судалгаа хийж байгаа учраас дээж авсан цэг болон гүн бүгд адилхан байх зарчмыг баримтлав.

“НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК-ийн Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори нь “Хонгорын орд” ХХК-ийн тусгай зөвшөөрөлтэй талбайгаас авсан ойн ширэгт бараан хөрс, уулын хүрэн хөрснөөс нийт 4 дээжинд үндсэн үзүүлэлт (уусмлын орчин рН, давсжилт, цахилгаан дамжуулах чадвар, ялзмаг, карбонат, кальци, магни, фосфор, кали), хөрсний механик бүрэлдэхүүн, хөрсөн дэхь хүнд метал (хром, хар тугалга, кадми, цайр, зэс, никель), эрүүл ахуйн 3, нийт 19 үзүүлэлтийг тодорхойлсон байна.

Хүснэгт 7 Мониторингийн судалгаа хийсэн байгалийн тогтоцоороо байгаа хөрсний агрохимийн харьцуулсан үндсэн үзүүлэлтүүд

Хөрс	Дээжний гүн, см	рН	Ялзмаг, %	Давс, %	CO ² , %	NO ³ мг/100гр	Шингээгдсэн суурь, мг-экв/100г		Шимт бодис, мг-экв/100г	
							Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
Ойн ширэгт	2021 онд хийсэн хөрсний агрохимийн үзүүлэлт									
	0-25	6,5	4,84	0,006	0,00	1,68	38	6	1,0	5

MV-016982 тоот “Цагаан чулуут” алтны үндсэн ордыг далдаар аргаар ашиглах төслийн талбайн 2022 оны байгаль орчны хяналт шинжилгээний тайлан

бараан хөрс	30-40	8,6	3,04	0,007	0,00	0,64	22	5	1,3	6
	<i>2022 онд хийсэн хөрсний агрохимийн үзүүлэлт</i>									
	0-25	6,8	4,44	0,06	0,00	1,24	28	10	3,9	14
	30-40	7,0	2,7	0,04	0,00	0,43	22	8	2,5	9
Уулын хүрэн хөрс	<i>2021 онд хийсэн хөрсний агрохимийн үзүүлэлт</i>									
	0-28	7,0	2,7	0,01	0,00	0,84	28	4	1,7	21
	28-38	8,2	0,9	0,03	1,44	0,11	13	17	1,2	32
	<i>2022 онд хийсэн хөрсний агрохимийн үзүүлэлт</i>									
	0-28	7,7	2,88	0,057	0,32	0,71	25	6	3,0	23
	28-38	8,1	1,42	0,061	1,24	0,17	18	5	1,2	20

Ойн ширэгт бараан хөрс. 2022 онд тус хөрсөнд агрохимийн задлан шинжилгээг давтан хийлгэж өмнөх он буюу 2021 онд хийсэн мөн шинжилгээтэй харьцуулан үзлээ. Энэхүү харьцуулалтыг баганаан тахирмагаар харуулав.




График 4. 2021, 2022 онд судалсан ойн бараан хөрсний агрохимийн харьцуулсан үзүүлэлт

Зураг ба-аас харахад хөрсний үндсэн үзүүлэлт болох ялзмагийн хэмжээ болон уусмлын орчин (рН)-ы үзүүлэлтэд зөвшөөрөгдөх хэмжээнээс их буюу бага тоон утга гараагүй байна. 2022 оны дээжинд задлан шинжилгээ хийлгэхэд ялзмагийн агууламжийн тоон утгад эргэлзээ байсан учраас бид давтан шинжилгээ хийлсэн юм. Энэхүү хоёр дахь шинжилгээгээр ялзмаг, уусмлын орчины үзүүлэлтүүд өмнөх (2021) оныхтой ойролцоо гарчээ.

Уулын хүрэн хөрс. 2022 онд тус хөрсөнд агрохимийн задлан шинжилгээг давтан хийлгэж өмнөх он буюу 2021 онд хийсэн мөн шинжилгээтэй харьцуулан үзлээ. Зураг бб-ээс харахад хөрсний үндсэн үзүүлэлт болох ялзмагийн хэмжээ болон уусмлын орчин (рН)-гийн үзүүлэлтүүд зөвшөөрөгдөх хэмжээнд байна. 2022 оны дээжинд задлан шинжилгээ хийлгэхэд ялзмагийн агууламжийн тоон утгад эргэлзээ байсан учраас бид давтан шинжилгээ хийлсэн юм. Энэхүү хоёр дахь шинжилгээгээр ялзмаг, уусмлын орчингийн үзүүлэлтүүд өмнөх (2021) оныхтой ойролцоо гарсан байна. Харин агрохимийн зарим үзүүлэлт, тодруулвал нитрат (NO³), кальци (Ca), магни (Mg), фосфор (P₂O₅), кали (K₂O) зэрэг бодисын агууламж их буюу бага гарсан тохихолдол ажиглагдаж байна (Зураг ба,б).

Эдгээр үзүүлэлтүүд нь ер нь “ХӨДӨЛГӨӨНТ” үзүүлэлт байдаг. Ийм учраас дараа дараачийн жилүүдийн үзүүлэлтүүдээс тодорхой болно.




График 5. 2021, 2022 онд судалсан уулын хүрэн хөрсний агрохимийн харьцуулсан үзүүлэлт

Ойн бараан болон уулын хүрэн хөрсний механик бүрэлдэхүүн бүх үе давхаргад 20-26% физик шавар агуулагдаж, нэршлийн хувьд дээрх 2 хөрс нь хөнгөн шавранцар байна (Хавсралт хүснэгт 1, 2). 2021 онд хийсэн судалгаанд 22-31% гэж байсан. Өөрөөр хэлбэл 2022 оны судалгааны тоон утгын хувьд ялимгүй зөрүүтэй боловч нэршлийн хувьд “хөнгөн шавранцар” байгаа учраас байгалийн тогтоцоор байгаа хөрсний механик бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй. Онолын хувьд нэршил зөрөхгүй байвал тоон утгад зөвшөөрөгдөх хэлбэлзэл байдаг (Доржготов, 2003. Хуудас 77-81, 103-112).

Хүнд металлын үзүүлэлт. 2021 оны судалгаанаас үзэхэд Ойн ширэгт бараан хөрсний “В” давхарга буюу 44-64 см-ийн гүнээс болон уулын хүрэн хөрсний “Вск” давхаргын 43-57 см-ийн гүнээс авсан дээжинд 6 хүнд металлын агууламжийг тодорхойлжээ. Кадмий (Cd) илрээгүй, хром (Cr) 36-95 мг/кг, хар тугалга (Pb) 14-43,7 мг/кг, цайр (Zn) 62,2-93,5 мг/кг, зэс (Cu) 32.5-43,1 мг/кг, никель (Ni) 22,6-115,3 мг/кг тус тус агуулагдаж байсан (2021 оны судалгааны тайлан). Эдгээр агууламж нь шавранцар (хөнгөн шавранцар) механик бүрэлдэхүүнтэй дээрх хоёр хэв шинжийн хөрсний хувьд бүгд хүлцэх хэмжээнд байж, аюулгүй, “хэвийн” байна (MNS 3297-2019, MNS5850:2019). Байгалийн нийц тогтоцоороо байгаа хөрсөнд мэдэгдэхүйц онцын өөрчлөлт ороогүй учраас 2022 онд хүнд металлуудыг тодорхойлох шаардлагагүй гэж үзлээ.

Харин алт олборлож байгаа компанийн суурьшлын төв-кемп (ажлын байр, гал тогоо, нүхэн жорлон)-ийн доод хэсэг болон 2022 оноос эхлэн алт олборлож, түүнд ашигласан усны хаягдал усан сан (нуур)-гийн далангийн шороонд хүнд металлуудын агууламжийг тус тус тодорхойлов (Хүснэгт 8, Зураг 7).

Хүснэгт 8 Хөрсний хүнд металл

Дээж авсан он ба гүн, см	Зэс (Cu), мг/кг	Кадми (Cd), мг/кг	Хар тугалга (Pb), мг/кг	Хром (Cr), мг/кг	Никель (Ni), мг/кг	Цайр (Zn), мг/кг
2021, 90-100	43,1	0,0	13,9	36,3	22,6	93,5
2022, 90-100	33,4	0,0	60,4	42,4	24,2	108,3
2022, хаягдал усны далан	17,7	0,0	0,0	32,3	40,2	63,5
Шавранцар хөрсөнд агуулагдах хүнд металлуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээ						
MNS 5850:2019	80	1,5	70	100	100	150



График 6. 2021, 2022 онд судалсан хөрсний хүнд металлын харьцуулсан үзүүлэлт

Хүснэгт 8 болон график 7-оос харахад хүнд металлын агууламж бүгд зөвшөөрөгдөх хэмжээнд байна. Өөрөөр хэлбэл хүлцэх хэмжээнээс бүгд бага байна. Харин хар тулгалгын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа боловч тоон утгын хувьд өмнөх оныхоос 4 дахин нэмэгдсэн байдал ажиглагдаж байна. Үүнийг дараах жилүүдийн тоон үзүүлэлтүүд ямар гарч байгаад анхаарал хандуулах хэрэгтэй. Нэг жилийн үзүүлэлтээр хар тулгалгын хэмжээ нэмэгдэж байна гэж дүгнэх нь учир дутагдалтай. Учир нь хүнд металлын тоон утга янз бүрийн хэлбэлзэлттэй гарах тохиолдол бий. Тийм учраас олон жилийн үзүүлэлтийг харах хэрэгтэйг энэ дашрамд дурдъя.

2022 оноос эхлэн алт олблорлож эхэлснээс үүдэлтэй хаягдал ус бий болж, усаа дахин ашиглаж байгаа юм байна. Ийм учраас үүссэн жижиг нуурын далангаас бид анх удаа дээж авч шинжлүүлэв.



График 7. Хаягдал усны далангийн шорооны хүнд металл, 2022 онд анх судалсан

Хүснэгт 8 болон график 7-оос харахад үүссэн жижиг нуурын усанд агуулагдах хүнд металлын агууламж мөн л бүгд зөвшөөрөгдөх хэмжээнд байна. Эл хаягдал усны далангаас жил бүр дээж авч харьцуулах болно.

Хүснэгт 9 Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ

№	Дээж авсан гүн, см	Нянгийн тоо, MNS 6341:2012	Гэдэсний савханцрын титр E.coli MNS 5367:2004		Анаэробын (CL.perfringens) MNS 6341:2012	
		Шинжилгээ	Шинжилгээ	Бохирдол	Шинжилгээ	Бохирдол
2021 онд хийсэн хөрсний эрүүл ахуй						
1	90-100	$1,9 \times 10^5$	0,1	2	0,1<	1
2022 онд хийсэн хөрсний эрүүл ахуй						
1	90-100	$2,5 \times 10^5$	1	1	0,1<	1
2	Усны далан	$3,3 \times 10^5$	1	1	0,1<	1

Шинжилгээний дүнгээс үзэхэд нянгийн тоо 2021 онд $1,9 \times 10^5$ байсан бол 2022 онд $2,5 \times 10^5$ байна. Үүнээс харахад стандартын хүлцэх хэмжээнд байж хөрс нянгаар бохирдоогүй байна. Өөрөөр хэлбэл бохирдлын зэрэг 10^6 зэрэгт хүрсэн тохихолдолд хөрсийг бохирдсон гэж үздэг.

Гэдэсний савханцарын титр 2021 онд 0,1 байжээ. Үүнээс үзэхэд бидний дээж авсан газарт гэдэсний савханцарын бохирдол “бага” буюу бохирдлын “2” гэсэн ангилалд хамрагдсан байна. Харин 2022 онд бохирдлын зэрэг “1” болж буурсан байна. Энэ нь хөрсний эрүүл ахуй хэвийн байгааг харуулж байна.

Анаэробын буюу хүчилтөрөгчгүй нөхцөлд агуулагдах нян 0,1< байна (Хүснэгт 6, хавсралт хүснэгт 2). MNS 6341: 2012 стандартаас харахад шинжилгээ хийсэн хөрс нянгаар бохирдоогүй “сайн” байна.

Усны далангийн шороонд 2022 оны байдлаар бохирдол байхгүй байна. Цаашид энд мониторингийн судалгаа хийх хэрэгтэй.

2.2.3 Дүгнэлт

1. Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Цагаан чулуут” хэмээх газарт “Хонгорын орд” ХХК MV016982 тоот тусгай зөвшөөрөлтэй газарт алт олборлож байна. Олборлолт явуулах нийт 84,5 га талбайгаас 12,3% буюу 10,4 га талбайд ойн бараа, 74,1 га буюу нийт талбайн 87,7%-д уулын хүрэн хөрс тус тус тархсан байгаа. Өөрөөр хэлбэл 2022 онд хөрсний талбайд өөрчлөлт ороогүй.
2. Мониторингийн судалгаанаас үзэхэд ойн бараан болон уулын хүрэн хөрс үржил шимээ алдаагүй, бохирдоогүй хэвийн байна.
3. Алт олборлож буй “Цагаан чулуут” хэмээх газарт хөрсний эрүүл ахуйн үнэлгээ хэвийн “сайн” байна.
4. Алт олборлохдоо ус ашиглаж байгаа бөгөөд түүнийгээ дахин аштглахын тулд жижиг нуурыг үүсгэжээ. Нуурын далангийн шороо хүнд металл болон эрүүл ахуйн хувьд бохирдоогүй хэвийн байна.

2.2.4 Санал

1. Хөрсний мониторингийн судалгааг жил бүр хийлгэхдээ нэг компаниар, хөрсний задлан шинжилгээ хийлгэсэн нэг л лабораториар тус тус хийлгэж байх хэрэгтэй. Учир нь олон жилийн судалгааны тоон утга зөрөхгүй, үр дүнг тооцоход эргэлзээ үүсдэггүй.

2.3. Усны хяналт шинжилгээ

Ашиглалтын үйл ажиллагаанд ашиглаж байгаа гүний усны эрэл хайгуулын ажлыг хийж гүйцэтгэж худаг гаргасан бөгөөд тус худгийг унд болон үйлдвэрлэлд ашигласан. Мөн хаягдал уснаас улиралд 1 удаа буюу 2 дээж авч шинжлүүлсэн.

Хүснэгт 10 Усны чанарын хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил

№	Усан орчин	Координат	Цэг сонгосон үндэслэл	Дээж авч буй фото зураг
1	1-р цэг. Гүний ус- Ундны ус	49° 07' 23.86" 106° 25' 57.20"	2022 оны БОМТ-нд тусгагдсан хяналт шинжилгээний цэг	

2	2-р цэг. Хаягдал ус	49° 8' 42.84" 106° 25' 23.63"	2022 оны БОМТ-нд тусгагдсан хяналтын шинжилгээний цэг	
---	------------------------	----------------------------------	--	--

Худгаас дээж авахдаа MNS ISO 5667-11:2000 “Гүний уснаас дээж авах зөвлөмж”-ийн дагуу, хаягдал уснаас дээж авахдаа MNS 4943:2015 стандартын дагуу тус тус авч 24 цагийн дотор лабораторид хүргүүлсэн.

2.3.1 Гүний усны хяналт-шинжилгээний үр дүн

Усны дээжийг зориулалтын аргаар ариутгасан шил болон 1 литрийн багтаамжтай хуванцар саванд авсан. Энэхүү хуванцар сав нь их концентраттай бодис бүхий дээж хадгалаагүй худалдааны цэвэршүүлсэн цэвэр усны хуванцар сав юм. Усны дээж авахдаа савыг дүүргэн авч саванд агаар байх зайгүйгээр тагласан. Энэ нь тээвэрлэлтийн үед сэгсрэгдэх, хийнүүдийн хоорондох харилцан үйлчлэлийг хязгаарлах ач холбогдолтой.

Хүснэгт 11 Усны ерөнхий химийн шинжилгээ – Худагаас

№	Химийн шинжилгээний үзүүлэлтүүд	Худгийн ус, мг/л	MNS 0900: 2018, мг/л
		2022.06.29	
1	Усан орчны (pH)	6.91	6.5-8.5
2	Cl ⁻	9.6	350
3	SO ₄ ⁻	9.5	500
4	CO ₃ ⁻	0	-
5	HCO ₃ ⁻	78.5	-
6	Na ⁺ +K ⁺	24.2	-
7	Ca ⁺⁺	52.3	100
8	Mg ⁺⁺	23.6	30

Шинжилгээний үр дүнгээр гүний худгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөн ус байна.

Анион катионуудын нийлбэр 310.6 мг/дм³, HCO₃⁻-ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр 213.0 мг/дм³, ерөнхий хатуулаг 3.09 мг-экв/л, pH= 6.91 цахилгаан дамжуулах чанар 354µS/cm, нийт ууссан бодис 212 ppm, физик чанарын хувьд тунгалаг ус байна.

2.3.2 Хаягдал усны хяналт-шинжилгээний үр дүн

Хаягдал усны хяналт шинжилгээг улиралд 1 удаа байхаар хаягдлын сангийн тунаагуураас MNS 4943:2015 стандартын дагуу 2022.05.26 авч “АЛС” лабораторид өгсөн мөн 2022.08.31-нд авч “Сэлэнгэ Цэнгэг Ус” усны шинжилгээний нэгдсэн лабораторид 24 цагийн дотор хүргүүлж шинжлүүлсэн.

Дараах шинжилгээний хариунаас харахад MNS 4943:2015 стандартаар дагуу шаардлага хангаж байна.

MV-016982 тоот “Цагаан чулуут” алтны үндсэн ордыг далдаар аргаар ашиглах төслийн талбайн 2022 оны байгаль орчны хяналт шинжилгээний тайлан

Хүснэгт 12 Хаягдал усны химийн шинжилгээ - Хаягдлын сан

№	ЭЛЕМЕНТ	НЭГЖ	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН	ЗӨВШӨӨРӨГДӨХ ХЭМЖЭЭ /MNS 4943:2015/	СТАНДАРТ АРГА
1	pH	-	6.56	6-9	MNS ISO 10523:2001
2	Чөлөөт хлор, Cl _{чөл}	мг/л	<0.10	1.0	
3	Хуурай үлдэгдэл, TDS	мг/л	181.3	1000	MNS 4423:1997
4	Умбуур бодис, TSS	мг/л	11.00	30	
5	Исэлдэх чадвар /KMnO ₄ /	мгO ₂ /л	8.00	20	
6	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, COD	мгO ₂ /л	41.00	50	MNS ISO 6060:2001
7	Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч, BOD	мгO ₂ /л	16.29	20	MNS ISO 5815:2001
8	Хүхэргүстөрөгч, H ₂ S	мг/л	<0.10	0.5	MNS 5597:2006
9	Хром, Cr (VI)	мг/л	<0.05	0.01	MNS ISO 11083:2001
10	Хөнгөнцагаан, Al	мг/л	<0.025	0.5	MNS (ISO) 11885:2011
11	Мышьяк, As	мг/л	<0.01	0.01	
12	Бор, B	мг/л	0.04	0.50	
13	Бари, Ba	мг/л	0.01	1.5	
14	Берелли, Be	мг/л	<0.001	0.001	
15	Кобальт, Co	мг/л	<0.001	0.02	
16	Кадми, Cd	мг/л	<0.005	0.03	
17	Хром, Cr	мг/л	<0.005	0.3	
18	Зэс, Cu	мг/л	<0.02	1.0	
19	Төмөр, Fe	мг/л	<0.03	1.0	
20	Марганец, Mn	мг/л	0.56	0.5	
21	Молибден, Mo	мг/л	0.01	0.5	
22	Никель, Ni	мг/л	<0.005	0.2	
23	Фосфор, P	мг/л	<0.05	1.5	
24	Хартугалга, Pb	мг/л	<0.01	0.1	
25	Сурьма, Sb	мг/л	<0.01	0.05	
26	Селен, Se	мг/л	<0.01	0.02	
27	Стронци, Sr	мг/л	0.21	2.0	
28	Ванади, V	мг/л	<0.01	0.10	
29	Уран, U	мг/л	<0.50	0.05	
30	Цайр, Zn	мг/л	<0.01	3.0	
31	Цианид, CN _{tot}	мг/л	<0.002	0.050	MNS ISO 6703(I):2006
32	Цианид, CN _{free}	мг/л	<0.002	0.050	MNS ISO 6703(II):2006
33	Мөнгөн ус, Hg	мг/л	<0.001	0.005	MNS 4420:1997

Агаарын дээжний хариу



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bchzll@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар ом/№	: 2022/A-248
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Хонгор орд” ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал	: Б.Батхшиг агаарын хэсэг
Дээжийн тоо, төрөл	: 2 агаар, 2 дуу чимээ
Сорьц авсан огноо	: 2022.09.06
Дээжийн тодорхойлолт	: Сэлэнгэ аймаг, Баянгол сум, 2-р баг, MV-016982 Алтны үндсэн орд
Шинжилгээний аргын стандарт	: MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021 CA3 A07-2016
Шинжилсэн огноо	: 2022.09.12
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн :	

№	Сорьц авсан цаг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт Тоос (TSP) мг/м ³
1	Үйлдвэрийн салхины дээр	09/06	12:30	0.009	0.027	0.115
2	Үйлдвэрийн салхины доор нуурын зуун талд	09/06	14:30	0.010	0.025	0.065
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500

Шинжилгээ гүйцэтгэсэн;
Агаарын хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан;
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга



Д.Түмэндэлгэр

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

Хөрсний дээжний хариу



“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сөнгөн Хайрхан дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-991 76123, 99231836
E-mail: nartkonsalting@gmail.com

№ 22/09-12/1

Засналагч: “Хөнгөрэн орд” ХХК
Дээж авсан цэг: Сэлэнгэ аймаг, Баянгол сум, MV-016982
Сорьц авсан огноо: 2022 оны 09 сар 07 өдөр
Шинжилгээ хийсэн огноо: 09 сарын 12
Хариуцах утас:

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Дээж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaCO ₃ , %	NO ₃ , мг/100г	Солилцох суурьд, мг-жв/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca ²⁺	Mg ²⁺	P ₂ O ₅	K ₂ O
Зүсэлт -1											
1	0-25	6.87	0.067	0.183	4.44	0	1.24	28	10	3.9	14
2	30-40	6.96	0.039	0.109	2.70	0	0.43	22	8	2.5	9
Зүсэлт -2											
3	0-28	7.72	0.057	0.157	2.88	0.32	0.71	25	6	3.0	23
4	28-38	8.11	0.061	0.167	1.42	1.24	0.17	18	5	1.2	20

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

№	Дээж авсан гүн, см	Механик шархэгууд, % шархэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Зүсэлт -1								
1	0-25	28.4	38.2	16.4	6.9	3.2	6.9	17.0
2	30-40	19.9	35.9	23.8	4.3	7.8	8.2	20.4
Зүсэлт -2								
3	0-28	23.8	44.6	9.0	7.0	6.0	9.5	22.5
4	28-38	14.7	42.5	16.4	12.3	5.5	8.6	26.4

3. ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН, IГР ХӨРСӨНД

№	Дээжний дугаар	Нянгийн тоо MNS6341-2012	Гэдэсний сакоаширын титр (E.coli)MNS 5367-2004		Анозробын (Clostridium) MNS 6341-2012	
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
1	Дээж 1 90-100см	2.5*10 ⁶	1	1	0.1<	1
2	Нуур	3.3*10 ⁶	1	1	0.1<	1

* Жэс: Эзлэхүү шинжилгээний хариу нь тухайн үзлийн дэглэмд хангагдана

4. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүй, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Дээж 1 90-100см	90-100	42.4	60.4	0.0	108.3	33.4	24.2
Нуур	-	32.3	0.0	0.0	63.5	17.7	40.2
Зөвшөөрснөө дээж хэмжээ MNS 5850:2019							
Элсэрхэг хөрө		60	50	1	100	60	60
Шаврангар хөрө		100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрө		150	100	3	300	100	150

*Харгалзах тунгш *Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн үзлийн дээжинд хамарма

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД: (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд MNS 3310:1991, MNS ISO 10390, хөрсний металлын бүрэлдэхүүн MNS 6824:2020, Зүүгч Ахуйн Шинжилгээний Стандарт MNS 3297:2019, Хүнд металлуудыг -хали дарсанд атом шинжилгээний спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭГТЭСЭН,
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ

Х.УУГАНЦЭЦЭГ, Д.ЭНХЧИМЭГ
Г.СОЛОНГО Ph.D



ХАНЛАБ ХХК
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17-р хороо, Богд Жавзлалын
гуудамж 1436 тоот, Хан Ринчин компанийн байр
Утас: 70109968, 99905318
<http://www.khanlab.mn>



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: ХОНГОРЫН ОРД ХХК, ЦАГААН ЧУЛУУТ
ТАЛБАЙ, MV-016982

ДЭЭЖИЙН ТӨРӨД,
ТОО

Саярл ус, 1

ЗАХИАЛН А №: 2022/0962

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2022.05.26

ШИНЖИЛСЭН ОГНОО: 2022.06.15

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдээгүй

ХУУДАСНЫ ТОО: 1

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дотоон хамгаара.
Дотоонгийн таларх асуудлыг манай лаборатори зарууцгаагүй болно.

Дэд захирал:

С.Туул, PhD

Хамтран ажилласан танд талархна.

MV-016982 тоот “Цагаан чулуут” алтны үндсэн ордыг далдаар аргаар ашиглах төслийн талбайн 2022 оны байгаль орчны хяналт шинжилгээний тайлан

ДЭЭЖИЙН ДУГААР: Саараа ус
ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-9793

№	ЭЛЕМЕНТ	НӨЛЖ	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН	ЗӨВЛӨӨӨРӨГ ДӨХ ХЭМЖЭЭ /MNS 4943:2015/	СТАНДАРТ АРГА
1	pH	-	6.56	6-9	MNS ISO 10523:2003
2	Чөлөөт хлор, Cl ₂	mg/l	<0.10	1.0	
3	Хуурай үлсгэлт, TDS	mg/l	101.1	1000	MNS 4473:1997
4	Уусуур бөмбөг, TSS	mg/l	11.00	30	
5	Беланий чанар /KMnO ₄ /	mg O ₂ /l	8.00	20	
6	Хавийн хэргэлдээг хүчилжүүлсэн, COD	mg O ₂ /l	41.00	50	MNS ISO 6060:2001
7	Биологийн хэрэгдэлг хүчилжүүлсэн, BOD	mg O ₂ /l	16.70	30	MNS ISO 5815:2001
8	Хүхэржүүлсэн, H.S	mg/l	<0.10	0.5	MNS 2597:2006
9	Хром, Cr(VI)	mg/l	<0.05	0.01	MNS ISO 11013:2001
10	Хлоридын ал, Al	mg/l	<0.025	0.5	
11	Мурлах, As	mg/l	<0.01	0.01	
12	Бор, B	mg/l	0.04	0.50	
13	Бар, Ba	mg/l	0.01	1.5	
14	Барелий, Be	mg/l	<0.001	0.001	
15	Кобальт, Co	mg/l	<0.001	0.02	
16	Кадмий, Cd	mg/l	<0.005	0.03	
17	Хром, Cr	mg/l	<0.005	0.2	
18	Зэс, Cu	mg/l	<0.02	1.0	
19	Төмөр, Fe	mg/l	<0.05	1.0	
20	Мэргэн, Mn	mg/l	0.56	0.5	MNS (ISO) 11085:2011
21	Молибден, Mo	mg/l	0.01	0.5	
22	Никель, Ni	mg/l	<0.005	0.2	
23	Фосфор, P	mg/l	<0.05	1.5	
24	Хартуукага, Pb	mg/l	<0.01	0.1	
25	Сурьма, Sb	mg/l	<0.01	0.05	
26	Селен, Se	mg/l	<0.01	0.02	
27	Стронци, Sr	mg/l	0.21	2.0	
28	Ванад, V	mg/l	<0.01	0.10	
29	Уран, U	mg/l	<0.50	0.05	
30	Цэдр, Zn	mg/l	<0.01	1.0	
31	Цагаан, CN ₂	mg/l	<0.002	0.050	MNS ISO 6703(1):2006
32	Цагаан, CN ₃	mg/l	<0.002	0.050	MNS ISO 6703(1):2006
33	Мөнгөн ус, Hg	mg/l	<0.001	0.005	MNS 4420:1997

Хуудас 1-1

СЭЛЭНГЭ ЦЭНГЭГ УС ОНӨААТҮГЭВЭР
УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ НӨГДСӨН ЛАБОРАТОРИ

213200 Сэлэнгэ аймгийн Сурбаанар сум
Т.р.Бат, 9-р хороо Цагаан чулуут-2021 Улаанбаатар 7098-3741



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он / № 20	Баянгол сум Цагаан чулуутын уурхай
Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	Техниин Б.Цогтбаяр
Дээж авсан хүний нэр, албан тушаал	10 литр усны дээж
Дээжийн хэмжээ, төрөл	2022.08 - 31
Хулэан авсан огноо	Гол юан, биогений элемент
Дээжийн тодорхойлолт	2022.08 - 03
Шинжилгээ хийн дууссан огноо	
Үр дүн	

УСНЫ ШИНЖИЛГЭЭ ДҮН

Шинжилгээний арлын стандартууд	Шинжилгээ хийсэн элементүүд	Нэгж	Үр дүн	MNS5148:2010
MNS ISO 10523 :2001	pH орчин		7.50	6.5-8.0
MNS 1097:1970	Кальци	мг/л	35.9	100
MNS 1097:1970	Магни	мг/л	14.0	30
MNS ISO 7150 : 2006	Аммоний ион	мг/л	0.40	3.0
MNS 6778:2019	Нитрит	мг/л	0.133	1.0
MNS 6834:2020	Нитрат	мг/л	1.154	50.0
MNS 4424 : 2005	Хлор	мг/л	14.2	350.0
MNS 6271 : 2011	Сулфат	мг/л	86.6	500.0
MNS 4430: 2005	Төмөр / нийт	мг/л	0.03	0.3
MNS 6831:2020	Гидрокарбонат	мг/л	212.3	
MNS 6778:2019	Хатуулаг	мг-экв/л	2.94	
MNS 6833 : 2020	Перманганатын исалдах чанар	мг/Ол	2.08	10.0
MNS 6272:2011	Фтор	мг/л	0.30	
MNS 1097:1970	Эрдэсжилт	мг/л	131.5	
MNS ISO 8876 :2001	Фосфор	мг/л	0.488	3.5
MNS 1097:1970	Най К	мг/л	68.5	
MNS ISO 7886: 1999	Цахилгаан дамжуулах чадвар EC	µs/cm	450.0	1000

Дүгнэлт:

"Хонгорын орд" ХХК-ны Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт үйл ажиллагаагаа явуулж буй Цагаан чулуутын уурхайгаас авсан дээжинд хийсэн усны шинжилгээний дүнг стандарттай харьцуулж үзэхэд MNS 6148:2019 стандартын дагуу байна.

Шинжилгээ хийсэн УШНЛ-н хямын

Шинжилгээг хийсэн УШНЛ-н эрхлэгч Д.Сүхбаатар

Хууль ёсоор заримдаг ажиллагаа

Сорилтын дүн зөвхөн шинжилгээний дэвсгэрийн хүрээнд зөвхөн